



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
САНДАГИЙН БЯМБАЦОГТ  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Бадамдоржийн ПУНСАЛМАА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-27-50, Факс: 32-70-16  
E-mail: punsalmaa@parliament.mn  
http://www.parliament.mn

2026.05.04 № УИХ-03/5030  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ПУНСАЛМАА

0000000042



Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

Ч.АНАР

А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Ж.БАТЖАРГАЛ

Р.БАТБОЛД

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ



2025.11.06.

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ

Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

0000000042

М.ГАНХҮЛЭГ  
Ц.ДАВААСҮРЭН  
Г.ДАМДИННЯМ  
Т.ДОРЖХАНД  
Б.ДЭЛГЭРСАЙХАН  
Б.ЖАВХЛАН  
Х.ЖАНГАБЫЛ  
Б.ЖАРГАЛАН  
Д.ЖАРГАЛСАЙХАН  
С.ЗАМИРА  
Б.ЗАЯАБАЛ  
Ж.ЗОЛЖАРГАЛ  
С.ЗУЛПХАР  
Ц.ИДЭРБАТ  
Ч.ЛОДОЙСАМБУУ  
Г.ЛУВСАНЖАМЦ  
С.ЛҮНДЭГ  
М.МАНДХАЙ  
Л.МӨНХБААТАР  
Ц.МӨНХБАТ  
Л.МӨНХБАЯСГАЛАН  
Т.МӨНХСАЙХАН  
Б.МӨНХСОЁЛ  
П.МӨНХТУЛГА

*Б. Мөнхсүрэн*

0000000042

Ц.МӨНХТУЯА



З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

Г.ОЧИРБАТ

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Д.ПҮРЭВДАВАА

Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ


Ц.ТУВААН



*Сарнайт*

0000000042

Б.ТУЛГА  
Б.ТҮВШИН  
Х.ТЭМҮҮЖИН  
Г.ТЭМҮҮЛЭН  
А.УНДРАА  
Ч.УНДРАМ  
Н.УЧРАЛ  
Б.УЯНГА  
Г.УЯНГАХИШИГ  
Д.ҮҮРИЙНТУЯА  
Г.ХОСБАЯР  
Б.ХЭРЛЭН  
Д.ЦОГТБААТАР  
Д.ЦОГТБААТАР  
О.ЦОГТГЭРЭЛ  
С.ЦЭНГҮҮН  
Ж.ЧИНБҮРЭН  
Б.ЧОЙЖИЛСҮРЭН  
Ө.ШИЖИР  
Л.ЭНХ-АМГАЛАН  
Б.ЭНХБАЯР  
Ж.ЭНХБАЯР  
Л.ЭНХНАСАН  
Д.ЭНХТУЯА



0000000042


Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН



0000000042



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Бадамдоржийн ПУНСАЛМАА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-27-50, Факс: 32-70-16  
E-mail: punsalmaa@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2026. 04. 23 № УИХ 03 / 4363  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх  
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу нэр бүхий гишүүдийн хамт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт <sup>13</sup> хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ПУНСАЛМАА

0000000053



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Б.ПУНСАЛМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 01. 12 № ХХТ/82  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 04 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265000629

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагаас санаачлан боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагаас санаачлан боловсруулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэж заасан тул тогтоолын төслийн нэрийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэж, үүнтэй уялдуулан тогтоолын төслийн 1, 2 дахь заалтын “улсын төсвийн” гэснийг “төсвийн” гэж тус тус өөрчлөх;


2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа анх батлагдсан төсөвт өртөг нэмэгдсэн, төлөвлөсөн хугацаанаас удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан, үндэслэлийг тодорхойлж, цаашид төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай эсэх мэдээллийг нэгтгэн боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах” гэж, 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг “Төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн боловч цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар худалдан борлуулах талаар холбогдох санал, дүгнэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах” гэж тус тус өөрчлөн найруулах;

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1, 3 дахь дэд заалтад тусгасан арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх боломжтой тул эдгээр заалтыг нэгтгэх;

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4, 5 дахь дэд заалтад тусгасан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээнд санал авах, эрэмбэлэх, үнэлэх, батлах үйл явцыг системчлэх болон гүйцэтгэлийн тоон мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зэрэг асуудлыг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх,

эрэмбэлэх, сонгох журам болон аргачлалууд”, 2023 оны 137 дугаар тушаалаар баталсан “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”-ын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр дамжуулан хэрэгжүүлж байгаа тул дээрх заалтуудыг хасах;

5.Тогтоолын төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөний үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад заасан аргачлалын дагуу боловсруулах, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн үзэл баримтлалд баталсан он, сар, өдрийг тусгах шаардлагатай.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН ..... Б.ПУНСАЛМАА

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ  
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1. Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах”, мөн “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан мэдээллийг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах болон хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно, мөн зүйлийн 14.3-д “Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын биелэлтийг мөн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй” гэж заасан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 4.1.10-т “төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг”; 24.6-д “төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”; 27.6-д “төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3-т “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгахыг хориглоно” гэж хуульчилсан.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.7-д “дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна”; 9.3.5-д “нийгэм байгаль орчин, эдийн засаг, засаглалын тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөгжлийн нэгдсэн зорилт, үйл ажиллагааны эрэмбэ дарааллыг тодорхойлох” гэж тусгасан.

Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Барилгын материалын үнэ болон ханшны өөрчлөлт, бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд санхүү, эдийн засгийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран үндэслэл, тооцоог хянаж, санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ”; 25 дугаар зүйлийн 25.5-д “Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ” гэж тусгасан.

32 дугаар зүйлийн 32.1.11-д “зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх”; 34 дүгээр зүйлийн 34.1.9-д “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох”; 34.1.4-т “барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах”; 34.1.10-т “барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох” гэж заасан.

Мөн Монгол Улсын тухайн жилийн төсвийн төсөлд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн хавсралтаар баталдаг. Төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тусган санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгахын тулд Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” -аар барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн талаар дараах зохицуулалтыг тусгасан.

- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалт “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”;
- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6 дахь заалт “тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх”.
- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”
- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7 “Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө.”

- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг “Гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хамаарч энэ хуулийн 29.7-д заасан нөхцөл байдал үүссэн нь хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг өөрчлөх үндэслэл болохгүй.” гэж заасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.3.5-д шинээр эхлэх төсөл, арга хэмжээгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 3 жилд багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлж дуусгадаг болсон нь цаашид улсын төсийн хөрөнгө оруулалтаар баригдах төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа буюу богино хугацаанд хэрэгжих боломж бүрдсэн нь сайн үр дүн юм. Харин хуулийн энэ зохицуулалт хэрэгжихээс өмнө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж эхэлсэн хэдий ч дуусаагүй үргэлжилж буй төсөл, арга хэмжээний явцыг үнэлж, эрэмбэлэх шаардлага үүссэн.

## 1.2. Практик шаардлага

Тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр батлагдсан төсөвт арга хэмжээ нь хэдэн жилийн дараа төсвийн тухай хуулийн төсөлд; төсөл, арга хэмжээний шилжих хөрөнгө оруулалт гэсэн ангилалаар төсөвт өртөг нь нэмэгдэх байдал жил бүр давтагдах болсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл арга хэмжээнүүдийн талаар судалж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар, улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг тодорхойлох, үнэлэх, шийдвэрлэх шаардлага бий болсон. Иймд улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж үзсэн төсөл, арга хэмжээг хувьчлах; дуудлага худалдаагаар худалдах, төр, хувийн хэвшил рүү шилжүүлэх зэргээр улсын төсөвт үүсэх ачаалал дарамтыг багасгаж, эргээд улсын төсөвт орлого төвлөрүүлэх бодит хэрэгцээ үүссэн.

Иймд, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуульд хавсралтаар баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж буй шалтнааныг судлах зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээ судалгааны үр дүнд гарсан тоон мэдээллийн зарим үзүүлэлтээс эш татаж, хүснэгт, диаграммаар үзүүлэв.

Сүүлийн 3 жилийн байдлаар улсын төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр давхардсан тоогоор 2537 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд үүнээс шилжих хөрөнгө оруулалтаар нэмэлт санхүүжилт хийгдсэн төсөл, арга хэмжээний нийт тоо давхардаагүй байдлаар 522 байна. Эдгээр төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн дүн нь 1.9 их наяд төгрөгт хүрсэн. Үүнийг Хүснэгт 1-ээр үзүүлэв.

*Хүснэгт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн тоо, зөрүү (сая төгрөгөөр)*

Төсвийн он	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Төслийн тоо	Зөрүү
2024	2,077,862.27	3,361,956.86	356	1,284,094.59
2025	491,075.92	745,496.60	71	254,420.68

2026	524,850.20	888,926.10	95	364,075.90
<b>Нийт дүн</b>	<b>3,093,788.39</b>	<b>4,996,379.56</b>	<b>522</b>	<b>1,902,591.17</b>

Эх сурвалж: Тогтоолын төсөл боловсруулах хүрээнд хийсэн хууль тогтоомжийн Хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа


2024 – 2026 оны улс төсөв дэх Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг жил бүрээр нь задлан шинжилж үзэхэд:

- 2024 оны байдлаар 449 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж байсан нь тухайн жилийн улсын төсвийн 25%, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нийт төсвийн 43%-ийг;
- 2025 оны байдлаар 142 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 971.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байсан нь тухайн жилийн улсын төсвийн 22%, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 23%-ийг;
- 2026 оны байдлаар 136 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 805.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байсан нь тухайн жилийн улсын төсвийн 23%, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 25%-ийг тус тус эзэлж байна.

Харин дээрх тоон үзүүлэлтээс сүүлийн 3 жилд он дамжин санхүүжилт тусгагдсан төслүүдийн давхардлыг арилган нийт шилжих хөрөнгө оруулалтаар төсөвт өртөг өссөн 522 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өссөн байдлаар нь, процентоор нь, үргэлжилсэн хугацаагаар, ангилан үзүүлбэл:

1. Төсөвт өртөг өссөн хувь хэмжээ
  - 1200% – 600% хүртэл өссөн 4 төсөл, арга хэмжээ;
  - 600% – 300% хүртэл өссөн 14 төсөл, арга хэмжээ;
  - 300% - 200% хүртэл өссөн 26 төсөл, арга хэмжээ;
  - 200% - 100% хүртэл өссөн 103 төсөл, арга хэмжээ;
  - 100% хүртэлх өссөн 375 төсөл, арга хэмжээ тус тус байна.
2. Үргэлжилсэн хугацаа
  - **10 ба түүнээс дээш жил** болж буй 21 төсөл, арга хэмжээ;
  - **5 – 9 жил** болж буй 140 төсөл, арга хэмжээ;
  - **1 – 4 жил** болж буй 361 төсөл, арга хэмжээ байна.

**Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг өөрчлөгдсөн байдлыг үргэлжилсэн хугацаа (насжилт)-аар нь авч үзвэл**



\* 10 ба түүнээс жил болж буй барилга  
 \* 5-9 жил болж буй барилга  
 \* 1-4 жил болж буй барилга

Өнөөгийн түвшинд шинэ төслүүдээс илүү, өмнө нь батлагдсан төслүүдээ дуусгахад төвлөрч байна. Жишээлбэл, 2024 онд 1319 төсөл, арга хэмжээнүүд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэхээс ердөө 26 нь шинэ төсөл, арга хэмжээ байв. 2025 онд 639 төслөөс 39 нь шинэ төсөл, арга хэмжээ; 2026 онд 579-өөс 149 нь шинэ төсөл арга хэмжээнүүд байсан. Энэ нь Засгийн газрын зүгээс, өмнө нь эхэлчихсэн төсөл, арга хэмжээнүүдээ дуусгах тал дээр илүүтэй анхаарч байгааг илтгэж байна. Гэхдээ эдгээр удчихсан, гацчихсан төсөл, арга хэмжээнүүд нь цаашид хэр хугацаанд үргэлжилж, улсын төсөвт ачаалал, дарамт үүсгэхийг тооцоолох боломжгүй байна. Тиймээс эдгээр төсөл, арга хэмжээнүүд дотроос нийгэм, эдийн засагт үр нөлөө багатай төслүүдийг эрэмбэлж, ангилж, цаашид дуудлага худалдаагаар оруулж, төсвийн ачаалал дарамтыг бууруулах хэрэгтэй. Улмаар энэхүү үүсэх төсвийн орон зайгаар нийгэм, эдийн засагт нэн нөлөөтэй шинэ төсөл, арга хэмжээнээс илүүтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр оруулж ирэх шаардлагатай байна.

*2024 – 2026 оны Төсвийн хуулиар баталсан нийт төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчаар ангилсан байдлаар дараах хүснэгтээр үзүүлбэл:*

*Хүснэгт 2.*

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төслийн тоо	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Зөрүү
1	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	1	450	628	178
2	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	4	45,600	51,323	5,723
3	БОЛОВСРОЛЫН САЙД	252	872,483	1,393,598	521,115
4	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	14	40,959	78,309	37,350
5	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	30	773,883	1,061,502	287,619
6	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	11	31,885	46,643	14,758
7	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	2	98,000	159,771	61,771
8	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	1	4,400	12,461	8,061
9	САНГИЙН САЙД	3	42,095	134,798	92,702
10	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	72	359,673	682,391	322,718
11	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	3	22,485	60,544	38,059
12	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	41	328,998	508,504	179,506
13	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	10	35,226	48,181	12,955
14	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	20	82,643	131,066	48,422
15	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	1	20,000	24,426	4,426
16	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1	15,000	75,955	60,955

17	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	47	191,303	325,223	133,921
18	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	9	128,707	201,059	72,352
<b>Нийт</b>		<b>522</b>	<b>3,093,788</b>	<b>4,996,380</b>	<b>1,902,591</b>

Эх сурвалж: Тогтоолын төсөл боловсруулах хүрээнд хийсэн хууль тогтоомжийн Хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа

Дээрх мэдээллээс 16 жилийн өмнө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр эхэлсэн төсөл өнөөдрийг хүртэл дуусаагүйн улмаас төсөвт өртгийг нэмэгдүүлж, улсын төсөвт тусгахаар оруулж ирж байгаа нь улсын төсөв дэх хөрөнгө оруулалтын талд багагүй асуудал байгааг илтгэж байна.

Улсын төсөв хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төсөвт тусгасан хэдий ч он дамнасан санхүүжилтийг нь дараа жилийн улсын төсөвт тусгаагүйгээс гүйцэтгэл саатаж олон жилээр гацсан, улмаар хожим төсөвт тусгахаар оруулж ирэхэд нь инфляцын нөлөөгөөр төсөвт өртөг нь олон дахин нэмэгдсэн төсөл, арга хэмжээ олон байна.

Зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгасны улмаас төсвийн тухайн жилдээ гүйцэтгэл хийгдэхгүй өнжих, улмаар төсөвт өртөг улсын төсөвт сууснаас өөрөөр магадлал хийгдэж нэмэгдэх байдалтай төслүүд олон байна.

Эх сурвалж: Тогтоолын төсөл боловсруулах хүрээнд хийсэн хууль тогтоомжийн Хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа

### **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг нь өсөөд байгаа, хугацаандаа дуусахгүй байгаа гол үндсэн шалтгаанууд**

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламжийн төрлийн төсөл арга хэмжээнд магадлал хийгдэж баталгаажсан зураг төсөвгүй төслүүдийг оруулж батлуулснаас голлох шалтгаан үүсдэг байна.
- Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангахгүй, батлагдсан зураг төсөвгүй төсөл арга хэмжээг Улсын Их Хурлын гишүүд олноор оруулж, баталснаас үүдэж бодит байдалд төсөвт өртөг өөрчлөгдөх бодит нөхцөлийг үүсгэдэг.
- Сонгуулийн жил угтсан төсвийн тэлэлтээр УИХ-ын гишүүд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд ихээр санал оруулах байдал нь төсвийн тухай хуулийн зарим шалгуурыг зөрчих байдал руу хүргэж байгаа,
- Тухайн жилийн төсвийн хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцад нэгдсэн мэдээллийн сан ашиглагддаггүй, салбар хоорондын уялдаа муу, төслийг эрэмбэлэх ажил салбарын яам дээр бус Сангийн яам дээр голчлон хийгддэг зэргээс зарим хэрэгжиж байсан төсөл арга хэмжээний тухайн жилийн санхүүжилт гээгдэх, орхигдох нөхцөл бий болгодог.
- Зарим барилга байгууламжийн төсөл арга хэмжээ олон жилийг дамнах явцад жилийн инфляцийн нөлөөнөөс хамаарч төсөвт өртөг нь төслийг дуусгах хэмжээнд хүрэхгүй болох эрсдэл үүсдэг.
- 2020 оны Ковидын үеийн хөл хорионоос хамаарч барилга байгууламжийн төслүүдийн бүтээн байгуулалт саатсанаас хамаарч олон жил дамнаж, улмаар

инфляцийн нөлөөнд өртөж, төсөвт өртөг нь хүрэлцээгүй болсон байх зэрэг үндсэн шалтгаан нөхцөл үүссэн байна.

Дээрх шалтгаан нөхцөлийг дэлгэрүүлвэл Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ч гүйцэтгэж дуусгалгүй зогссон, дараа жилүүдийн төсвийг улсын төсөвт тусгалгүй гацаасан, анх батлагдсан төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл, арга хэмжээний талаар судалж, Сангийн яам, Барилгын хөгжлийн төвөөс холбогдох мэдээлэл авч харьцуулж, улмаар Авилгатай тэмцэх газар, Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын дүгнэлттэй тулган үзэж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төслүүдэд үүсч буй асуудлуудыг дурьдвал:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр эхэлсэн ч төсөл өнөөдрийг хүртэл дуусаагүйн улмаас төсөвт өртгийг нь нэмэгдүүлж улсын төсөвт тусгахаар оруулж ирж байгаа нь улсын төсөв дэх хөрөнгө оруулалтын талд ихээхэн асуудал байгааг илтгэж байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төсөвт тусгасан хэдий ч он дамнасан санхүүжилтийг нь дараа жилийн улсын төсөвт тусгаагүйгээс гүйцэтгэл саатаж олон жилээр гацсан, улмаар хожим төсөвт тусгахаар оруулж ирэхэд нь инфляцын нөлөөгөөр төсөвт өртөг нь олон дахин нэмэгддэг.
3. Зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгасны улмаас төсвийн тухайн жилдээ гүйцэтгэл хийгдэхгүй өнжих, улмаар төсөвт өртөг улсын төсөвт тусгагдсан ч магадлал хийгдэж нэмэгддэг.
4. Төсөвт өртгийг нь таамгаар тусгаснаас хамаарч дараа нь зураг төсвийг нь баталгаажуулахад бодит байдал дээр төсөвт өртөг нь нэмэгдсэн, хөрөнгө дутсаны улмаас зогсдог.
5. Нэг маягийн зураг, жишиг төсөв ашиглаж улсын төсөвт тусгасан төсөл, арга хэмжээг тухайн байршилд барихаар барилгын зургийн холболт, тохируулга хийх явцад төсөвт өртөг өөрчлөгдөн нэмэгддэг.
6. Гүйцэтгэгч компанийн чадавх, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалтгүй байдлаас уг барилга, байгууламжийн төсөл баригдахгүй зогссон төслүүд байна.
7. Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, бүртгэл, барилгын ажлын гүйцэтгэлийн төлөвлөлт, бэлтгэл ажил зэрэг нь хангалтгүйн улмаас төсөл хугацаандаа хэрэгжиж ашиглалтад ордоггүй.
8. Худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулдаггүй эсвэл захиалагч тал гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн явцад тухай бүр хяналт тавьдаггүйн улмаас чанарын шаардлага хангахгүй зогссон.
9. Барилга угсралтын ажил болон захиалагч, гүйцэтгэгч компаниудын явцын хяналт дотоод зохион байгуулалт хангалтгүйн улмаас улсын комисс хүлээж авахад зөрчил, доголдол илэрч, акт тавихад түүнийгээ засаж хүлээлгэн өгч чадаагүйн улмаас төсөл зогссон.
10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээ нь газар чөлөөлөлтийг шийдвэрлээгүйн улмаас барилгын ажил эхлэхгүй саатсан тохиолдлууд байна.

11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төсөвт тусгаж, тендер зарлаж гэрээ байгуулсан хэдий ч явцын дунд барилгын ажил гүйцэтгэх гэрээг цуцалсны улмаас зогссон төсөл, арга хэмжээ байна.

Барилга, байгууламжийн төсөлд тавигддаг норм стандартыг хангадаггүйн улмаас мөн улсын комисст хүлээлгэн өгөх боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаар; төсөл, арга хэмжээний үлдэгдэл ажлын тоо хэмжээг үндэслэн шинэчилсэн төсөв гаргуулдаг шалтгаан зэргийг Аудитын тайлан болон Сангийн яам болон Барилга Хөгжлийн Төвөөс ирүүлсэн мэдээлэлд дурджээ.

### **Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийн зорилго нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсөвт өртгийн үндэслэлгүй өсөлтийг бууруулах, зогссон болон удааширсан төслүүдийг эрэмбэлэх, төлөвлөлт болон шийдвэр гаргалтыг ил тод, өгөгдөлд суурилсан болгох, мөн төсвийн сахилга бат, хариуцлагыг бэхжүүлэхэд оршино.

#### **2.1. Тогтоолын төслийн бүтэц**

Улсын Их Хурлын тогтоолын төслийг нь 4 заалттай ба 1-р заалт нь дотроо 5 дэд заалттайгаар боловсруулсан болно.

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар даалгах заалт,
- Тухайн жилийн төсвийн тухай хуулиар төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төсөл арга хэмжээнд тавигдах шаардлагыг хянах хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийн нийцлийг хангах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлд зохион байгуулалтын арга хэмжээг авч, тухай бүр мэдээлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгах заалт,
- Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах заалт,
- Тогтоолыг дагаж мөрдөх хугацаа тогтоох заалт гэсэн үндсэн бүтэц байна.

#### **2.2. Тогтоолын төслийн агуулга**

Тогтоолын төслийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар даалгах” 1-р заалт нь 5 дэд заалттай байх бөгөөд дараах агуулгыг тусгалаа. Үүнд:

1/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл, арга хэмжээнүүдийн талаар судалж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар, улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ бүрээр тус бүр үнэлж, тайланг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

2/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хэдий ч дуусгалгүй зогсоосон, цаашид улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар төр, хувийн хэвшилд шилжүүлэх санал, дүгнэлтийг нэг бүрчлэн гаргаж 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

3/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээ хугацаандаа орохгүй саатаж буй болон анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлан, төсөвт дарамт үүсгэж буй шалтгааныг арилгах арга хэмжээ авах;

4/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл,, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг бодит цагийн байдлаар харах, ашиглах, боломжоор хангах, мэдээллийг нэгтгэн системчлэх, стандартчилах;

5/ Улсын Их Хурлаар улсын жилийн төсөв хэлэлцэн батлах хугацаанд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29<sup>1.4</sup> -т заасан систем дэх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд бүхэлд нь харах боломжоор хангах.

**Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Тогтоолын төсөл батлагдсанаар Засгийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн ч төсөвт өртөг нь нэмэгдсэн, зогссон, цаашид санхүүжүүлэхгүй зэрэг төсөл, арга хэмжээг нэг бүрчлэн судалж дүгнэлт гарган, улмаар гүйцээн санхүүжүүлэх, худалдан борлуулах, хувьчлах зэрэг байдлаар шийдвэрлэж 2026 оны төсвийн төслөөс өмнөх бүх асуудал дагуулсан төсөл, арга хэмжээг цэгцлэх ажил хийгдэнэ.

УИХ-ын тогтоол хэрэгжсэнээр дараах үр дүн гарахаар тооцож байна. Үүнд:

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулдаг болно. Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т заасны дагуу зөвхөн инфляцын түвшингөөр төсөвт өртөг нэмэгдэнэ.
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэж зааснаар ТЭЗҮ-гүй, батлагдсан зураг төсөвгүй, газрын асуудал шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээг тухайн жилийн улсын төсөвт тусгахгүй байх нөхцөл бүрдэнэ.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл явцад ашиглаж буй “цахим сан”-ийн мэдээллийг шийдвэр гаргах түвшинд буй УИХ-ын гишүүд улсын төсөв хэлэлцэн батлахдаа ашигладаг болж, мэдээллээр хангагдах боломж бүрдэнэ.
4. Сүүлийн 3 жилийн байдлаар төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэнтэй адил төсвийн ачаалал, дарамтыг цаашид улсын төсөвт үүсэхээс сэргийлнэ.

**Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар**

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно. Тогтоолын төсөл нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл болох Хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн хэрэгжилтийг хангахад чиглэгдэх болно.

---oOo---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”  
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийн зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсөвт өртгийн үндэслэлгүй өсөлтийг бууруулах, зогссон болон үр ашиггүй төслүүдийг эрэмбэлэх, төлөвлөлт болон шийдвэр гаргалтыг ил тод, өгөгдөлд суурилсан болгох, мөн төсвийн сахилга бат, хариуцлагыг бэхжүүлэхэд оршино.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд нийт 579 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасны 2.0 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 136 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг нь 805.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Монгол Улсын 2024, 2025 оны улсын төсөв, 2026 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасан нийт төсөл, арга хэмжээний давхардлыг нь арилгаж үзэхэд 3 жилийн хугацаанд 2010 оноос хойш анх батлагдаж төсвөөс санхүүжүүлж ирсэн 522 төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг 2026 оны байдлаар 1.9 их наядаар нэмэгдсэн дүнтэй харагдаж байна. Энэ нь улсын төсөвт ихээхэн хэмжээний дарамт үзүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого алдагдуулах, улмаар төсвийн хөрөнгө оруулалтаар цаашид санхүүжүүлж болох нийгэм, эдийн засгийн олон үр дүнтэй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжийг хязгаарлан өмнөх төслүүдийн нэмэгдсэн дүнг санхүүжүүлэхэд зарцуулж байгааг цаашид залруулах шаардлагатай байна гэж үзэж тухайн асуудлаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачилсан болно.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг олон талын оролцоонд тулгуурлан боловсронгуй болгох зорилгоор мэргэжлийн байгууллага, холбоод, холбогдох мэргэжилтнүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд 41 мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Мөн олон нийтийн санал авах зорилгоор D-Parliament.mn цахим сүлжээнд 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр байршуулсан.

Засгийн газраас санал авах хүсэлтээ 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр УИХ – 03/12077 тоот албан бичгээр уламжилсны үндсэн дээр Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлийг хүргүүлсэн. Тус хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар зарчмын хувьд дэмжсэн бөгөөд уг саналыг 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн ХЭГ/82 дугаартай албан бичгээр албажуулан ирүүлсэн. Засгийн газраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий

болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэж заасан тул тогтоолын төслийн нэрийг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай үүнтэй уялдуулан тогтоолын төслийн 1, 2 дох заалтын “улсын төсвийн” гэснийг “төсвийн” гэж тус тус өөрчлөх санал гаргасан.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг нь 4 заалттай ба 1-р заалт нь дотроо 5 дэд заалттайгаар боловсруулсан болно.

---o0o---

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ  
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.” гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан мэдээллийг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах болон хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно, мөн зүйлийн 14.3-д “Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын биелэлтийг мөн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй” гэж заасны дагуу тогтоолын төслийг санаачилсан.

Монгол Улсын тухайн жилийн төсвийн төсөлд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ төсөл, арга хэмжээг тусгаж, Төсвийн тухай хуулийн хавсралтаар баталдаг.

Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг жил бүр батлан хэрэгжүүлж ирсэн боловч сүүлийн жилүүдэд эдгээр төслүүдийн анх батлагдсан төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилтийн хугацаа сунжрах, гүйцэтгэл саатах, зарим тохиолдолд зогсох зэрэг асуудал тогтмол давтагдаж байна. Тухайлбал, 2024 онд нийт 449 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж, энэ нь тухайн жилийн нийт хөрөнгө оруулалтын 43 хувийг эзэлсэн бол 2025 онд 142 төсөл, арга хэмжээний төсөв 971.3 тэрбум төгрөгөөр, 2026 онд 136 төсөл, арга хэмжээний төсөв 805.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Мөн 2024 – 2026 оны төсөв болон төсвийн төслийн хүрээнд давхардлыг арилган тооцоход нийт 522 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 1.9 их наяд төгрөгөөр өссөн нь улсын төсөвт ихээхэн дарамт учруулж байна. Мөн тухайн бүс нутгийн иргэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй авах эрх нь хязгаарлагдаж байна. Энэ нь төсвийн сахилга бат, төлөвлөлтийн чанар хангалтгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг буурч байгааг мөн шинэ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв санхүүгийн боломж хязгаарлагдаж байгааг тус тус илэрхийлж байна.

Судалгааны дүнгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртөг нэмэгдэхэд хэд хэдэн суурь шалтгаан нөлөөлж байна. Тухайлбал:

Нэгдүгээрт, төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөв, магадлалын дүгнэлтгүйгээр улсын төсөвт тусгаж, дараагийн шатанд магадлал хийгдэх үед бодит өртөг нэмэгдэх нөхцөл бүрдэж байгаа.

Хоёрдугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн нэгдсэн систем, стандарт хангалтгүй байгаа нь санал авах, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцын уялдаа алдагдах шалтгаан болж байна.

Гуравдугаарт, улсын төсвийн хэлэлцүүлэг, батлах үе шатанд улс төрийн болон субъектив нөлөөллийн улмаас бэлтгэл хангагдаагүй буюу хуулийн шаардлага хангаагүй төслүүд гэнэт төсөвт нэмэгдэх тохиолдол гарч байна.

Дөрөвдүгээрт, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдэд байршлын онцлогт тохироогүй жишиг зураг төсөл ашиглах нь гүйцэтгэлийн явцад нэмэлт ажил, нэмэлт зардал үүсгэх; харин олон жил дамжин хэрэгжиж буй төслүүдийн хувьд санхүүжилтийн тасалдал болон инфляцын нөлөөлөл нь төсөвт өртөг нэмэгдэхэд ихээхэн нөлөөлж байна.

Тавдугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн гүйцэтгэгч байгууллагын хүний нөөц, техник, санхүүгийн чадавх сул байх нь ажлын гүйцэтгэл удаашрах, зардал нэмэгдэх шалтгаан болж байгаа бол захиалагч болон хяналтын байгууллагын хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгаагаас алдаа, зөрчил давтагдах нөхцөл бүрдэж байна.

Зургаадугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд газар чөлөөлөлт, инженерийн шугам сүлжээний холболт зэрэг бэлтгэл ажил хангалтгүй үед төслийг хэрэгжүүлснээр нэмэлт зардал, хугацааны хойшлох байдал, мөн Ковид – 19 цар тахал зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр зарим төсөл, арга хэмжээ саатаж, улмаар төсөвт өртөг нэмэгдэхэд хүрсэн байна.

Эдгээр хүчин зүйлсүүд нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн чанарт сөргөөр нөлөөлж, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгож байгааг харуулж байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас зогссон болон удааширсан төсөл, арга хэмжээг нэгтгэн, нэг удаагийн байдлаар дахин үнэлж, тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу цэгцлэх шаардлага үүссэн тул уг асуудлыг зохицуулах зорилгоор тогтоолын төслийг санаачлах үндэслэл бүрдэж байна.

Тогтоолын төслийг баталснаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн чанар сайжирч, төсвийн сахилга бат, хариуцлагын тогтолцоо бэхжих нөхцөл бүрдэнэ. Үүний үр дүнд төсөвт өртгийн үндэслэлгүй болон хэт өсөлт буурах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт илүү бодит үндэслэлтэй, өгөгдөлд суурилсан болох боломжтой болно. Мөн зогссон болон удаашралтай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг нэгдсэн байдлаар судалж, ангилж шийдвэрлэх замаар улсын төсөвт үүсч буй санхүүгийн дарамт багасах, үр ашиггүй зарцуулалт хумигдах, төсвийн хөрөнгийн өгөөж

нэмэгдэх эерэг үр нөлөө бий болно. Энэ нь шинэ төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх орон зайг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогын үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой. Өнөөдрийн байдлаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдийн зогссон, удааширсан, төсөвт өртөг нэмэгдсэн талаарх нэгдсэн үнэлгээ, жагсаалт, төсөвт өртгийн тооцоход дутмаг байна.

Мөн төлөвлөлт болон мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх нь оновчтой, бодитой шийдвэр гаргахад ач холбогдолтой бөгөөд төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, давхардал болон хийдлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ. Иймд энэхүү тогтоолын төсөл хэрэгжсэнээр төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэж, санхүүгийн сахилга бат сайжрахын зэрэгцээ төрийн шийдвэр гаргалт илүү оновчтой, ил тод, тогтвортой болох үр дүнтэй.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн заалт, тус бүрээр танилцуулвал, 4 заалттай ба 1-р заалт нь дотроо 5 дэд заалттайгаар боловсруулсан болно.

Нэгдүгээр заалт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх асуудлыг 5 дэд заалтаар тодорхойлж Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасан агуулга тусгагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл арга хэмжээнүүдийн талаар судалж, түүнийг үнэлж, эрэмбэлж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан; нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар; улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг үнэлж, тодорхойлж, тайланг танилцуулах; мөн цаашид улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төсөл арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар худалдан борлуулах санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах хугацаатай чиглэл өгч байна.

Төсөл, арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлан, жил бүрийн улсын төсөвт дарамт үүсгэж буй шалтгааныг арилгах арга хэмжээ авах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, үнэлэх, төлөвлөх, батлах үйл явцын тоон мэдээллийг системчлэх, стандартчилах, төсвийн төлөвлөлт, Улсын Их Хурлаар баталсан, өөрчлөн баталсан болон төсвийн гүйцэтгэлийн тоон мэдээллийн нэгдсэн сан үүсгэн шийдвэр гаргагчид үйл ажиллагаандаа ашиглахад хялбаршуулах зэрэг асуудлыг Засгийн газарт даалгасан агуулгыг тогтоолын төслийн 1 дүгээр заалтад тусгасан.

Хоёрдугаар заалт: Тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төсөл арга хэмжээнд тавигдах шаардлагыг хянах хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийн нийцлийг хангах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлд зохион байгуулалтын арга хэмжээг авч, тухай бүр мэдээлж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгасан.

Гуравдугаар заалт: Хоёрдугаар заалтад заасан дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газарт даалгасан.

Дөрөвдүгээр заалт: Уг тогтоолын төсөл батлагдсан өдрөөс дагаж мөрдөхөөр тусгав.

---o0o---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

### **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл, арга хэмжээнүүдийн талаар судалж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар, улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ бүрээр тус бүр үнэлж, тайланг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

2/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хэдий ч дуусгалгүй зогсоосон, цаашид улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар төр, хувийн хэвшилд шилжүүлэх санал, дүгнэлтийг нэг бүрчлэн гаргаж 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

3/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээ хугацаандаа орохгүй саатаж буй болон анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлан, төсөвт дарамт үүсгэж буй шалтгааныг арилгах арга хэмжээ авах;

4/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг бодит цагийн байдлаар харах, ашиглах, боломжоор хангах, мэдээллийг нэгтгэн системчлэх, стандартчилах;

5/ Улсын Их Хурлаар улсын жилийн төсөв хэлэлцэн батлах хугацаанд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29<sup>1.4</sup> -т заасан систем дэх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд бүхэлд нь харах боломжоор хангах.

2.Тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хянах хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийн нийцлийг хангах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлд зохион байгуулалтын арга хэмжээг авч, тухай бүр мэдээлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгасугай.

3.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

# **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР  
ТӨСВИЙН ХУУЛЬД ТУСГАЖ БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БУЙ АСУУДЛААР  
ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ  
БОЛОВСРУУЛАХ ХҮРЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА**

Захиалагч: Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа

Гүйцэтгэгч: Полиси Ньюс Аженси ХХК

Улаанбаатар хот

2025 он

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	3
ГАРЧИГ .....	5
Нэг. УТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСВИЙН ХУУЛЬД ТУСГАЖ БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БУЙ АСУУДАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	5
1.1. Үнэлгээ хийх шалтгаан.....	5
1.2. Төсвийн төлөвлөлтөд санал авах, эрэмбэлэлт, батлах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үйл явц, түүний мэдээлэл нь шийдвэр гаргах түвшинд ил бус байгаа асуудал .....	16
1.3. Үнэлгээ хийх хүрээ .....	17
2024 онд УТХО-аар нийт 1319 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. ....	17
2025 онд УТХО-аар нийт 639 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. ....	18
2026 онд УТХО-аар нийт 579 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. ....	18
1.4. Шалгуур үзүүлэлт .....	19
1.5. Харьцуулах хэлбэр.....	20
1.6. Мэдээлэл цуглуулах арга.....	22
Хоёр. УТХО-ААР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БУЙ БАЙДЛЫН СУДАЛГАА.....	23
2.1. Монгол Улсын 2024, 2025, 2026 оны төсөвт тусгагдсан УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн судалгаа, Үндэсний аудитын газрын дүгнэлт .....	23
2.1.1. УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....	23
2.1.2. ТАХ-НЫ ТӨСӨЛТ ӨРТӨГ ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ҮНДСЭН ШАЛТГААНУУД .....	27
2.1.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ .....	31
2.2. 2024-2025 оны улсын төсвийн тухай хууль, 2026 оны Улсын төсвийн тухай хуулийн төсөл дэх УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтөд хийсэн дүгнэлт	35
Гурав. ҮНЭЛГЭЭ.....	45
3.1. Хууль тогтоомж хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэх .....	45
3.2. Тоон болон чанарын үнэлгээ .....	45
Дөрөв. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	52
Хавсралт 1. МУ-ын 2024 оны төсвийн тухай хуульд УТХО-аар санхүүжүүлсэн ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдсөн байдал.....	54
Хавсралт 2. МУ-ын 2025 оны төсвийн тухай хуульд УТХО-аар санхүүжүүлсэн ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдсөн байдал.....	81
Хавсралт 3. МУ-ын 2026 оны төсвийн тухай хуульд УТХО-аар санхүүжүүлсэн ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдсөн байдал.....	90
Ашигласан материал .....	100

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үгс	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНБД	Барилгын норм ба дүрэм
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХС	Батлан хамгаалахын сайд
БХТ	Барилгын хөгжлийн төв
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕТГД	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
МУСНУБХТБҮХД	Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
ОНБТСҮХД	Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар

ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮГ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам

---

## ГАРЧИГ

### Нэг. УТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСВИЙН ХУУЛЬД ТУСГАЖ БАТАЛСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БУЙ АСУУДАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

#### 1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Тухайн жилийн төсвийн тухай хуулиар УТХО-аар санхүүжүүлэхээр тусгагдаж, батлагдсан төсөл арга хэмжээний төсөвт өртөг хэдэн жилийн дараа дахин улсын төсвийн хуулийн төсөлд нэмэгдэж өөрчлөгдөн орж ирэх байдал жил бүр давтагдах болсон. Тухайлбал, 2025 оны төсвийн тухай хуулийг 2024 оны намар хэлэлцэх үед 2010-2023 оны хооронд улсын төсөвт тусгагдсан нийт 109 төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж, нэмэгдсэн төсөвт өртгийн зөрүү нь 931 тэрбум төгрөг болсон нь тухай жилд УТХО-аар санхүүжүүлэх нийт төсөл арга хэмжээний нийт төсвийн 22.7%-тай дүйж байсан.

Сүүлийн 3 жилийн төсвийн тухай хуульд батлагдсан УТХО-ийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд 2024 онд нийт 449 төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөв нийт дүнгээр 1.6 их наяд төгрөг, 2025 онд 142 төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөв нийт дүнгээр 971.3 тэрбум төгрөг, 136 төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөв нийт дүнгээр 805.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1.1. Анх батлагдсан төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл арга хэмжээний нэр, 2024-2026 он. /давхцлыг нь арилгаагүй байдлаар тухай жилдээ орж ирсэн байдлаар/*

УТХО-ийн төсөл арга хэмжээ		2024	2025	2026
УТХО-ын нийт төсөл арга хэмжээ	Тоо	1,319	639	579
	Анхны төсөвт өртөг. сая.төг	4,082,097	6,502,096	6,205,278
	Сүүлийн төсөв сая.төг	11,516,391	12,134,006	9,631,880
	Тухайн жилийн санхүүжих дүн. сая.төг	3,765,314	4,145,615	3,267,318
Анхны төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл арга хэмжээ	Тоо	449	142	136
	Анхны төсөвт өртөг. сая.төг	2,579,116	1,705,383	1,241,276
	Сүүлийн төсөв сая.төг	4,195,948	2,676,730	2,046,300
	Нэмэгдсэн зөрүү. сая.төг	1,616,832	971,347	805,024

Дээрх хүснэгтээс улсын төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг нь хэдэн жилийн дараа их хэмжээгээр нэмэгдэж буй байдлыг тодорхой харж болохоор

байна. 2024 оны байдлаар 449 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж байсан нь тухайн жилийн төсөл арга хэмжээний 25%, УТХО-аар санхүүжүүлэх нийт төсвийн 43%-ийг тус тус эзэлж байжээ.

2025 оны байдлаар 142 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 971.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байсан нь тухайн жилийн төсөл арга хэмжээний 22%, УТХО-аар санхүүжүүлэх нийт төсвийн 23%-ийг тус тус эзэлж байжээ.

Харин Монгол Улсын 2026 оны байдлаар 136 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 805.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байсан нь тухайн жилийн төсөл арга хэмжээний 23%, УТХО-аар санхүүжүүлэх нийт төсвийн 25%-ийг тус тус эзэлж байжээ.

### **Төсөвт өртөг нэмэгдэж байгаа асуудлууд:**

Судалгаанд дараах байдлаар урьдчилсан таамаглал дэвшүүлж, уг таамаглалыг нотлох байдлаар судалгааны арга боловсруулж ажиллана. Үүнд:

- УТХО-аар санхүүжүүлэх барилга байгууламжийн төрлийн төсөл арга хэмжээнд магадлал хийгдэж баталгаажсан зураг төсөвгүй төслүүдийг оруулж батлуулснаас үүдэж батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж нэмэгдэх голлох шалтгаан болно,
- УИХ-ын гишүүдэд тойрогтоо УТХО-аар төсөл арга хэмжээ оруулах албан бус “эрх, боломж” олгодог нь төсвийн тухай хуулийн дээрх шаардлагыг хангахгүй, батлагдсан зураг төсөвгүй төсөл арга хэмжээг олноор баталснаас үүдэж бодит байдалд төсөвт өртөг өөрчлөгдөх нөхцөл үүсэх,
- Сонгуулийн жил угтсан төсвийн тэлэлтээр УИХ-ын гишүүд УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд ихээр санал оруулах байдал нь төсвийн тухай хуулийн зарим шалгуурыг зөрчих байдал руу хүргэж байгаа,
- Тухайн жилийн төсвийн хуульд УТХО-ын төсөл арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцад нэгдсэн мэдээллийн сан ашиглагддаггүй, салбар хоорондын уялдаа муу, төслийг эрэмбэлэх ажил салбарын яам дээр бус Сангийн яам дээр голчлон хийгддэг зэргээс зарим хэрэгжиж байсан төсөл арга хэмжээний тухайн жилийн санхүүжилт гээгдэх, орхигдох нөхцөл бүрдэж байгаа,
- Зарим барилга байгууламжийн төсөл арга хэмжээ олон жилийг дамнах явцад жилийн инфляцийн нөлөөнөөс хамаарч төсөвт өртөг нь төслийг дуусгах хэмжээнд хүрэхгүй болох зэрэг эрсдэл бий болж байна.
- 2020 оны Ковидын үеийн хөл хорионоос хамаарч барилга байгууламжийн төслүүдийн бүтээн байгуулалт саатсанаас хамаарч олон жил дамнаж, улмаар инфляцийн нөлөөнд өртөж, төсөвт өртөг нь хүрэлцээгүй болсон байх зэрэг таамаглалыг дэмшүүлж байна.

2024 оноос өмнөх жилүүдийн төсвийн тухай хуулийн УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үндсэн тоон мэдээлэл, жагсаалтад анх батлагдсан төсөвт өртгийг оруулдаггүй байснаас хамаарч 2023 болон түүнээс өмнөх жилүүдэд батлагдсан төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн эсэхийг тодруулахад хүндрэлтэй байгаа ба Сангийн яам, Барилгын хөгжлийн төвөөс мэдээлэл авч тодруулах шаардлагатай байна.

## **Төсвийн төлөвлөлт хуульд нийцэхгүй байгаа асуудал:**

УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртөг нь өсөж буй байдлын ард төсвийн төлөвлөлт төсвийн тухай хуульд нийцэхгүй байгаа асуудлууд байна. Тухайлбал,

- Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэж Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан байдаг. Гэтэл ТАХ-г УТХО-аар санхүүжүүлэхээр санал өгөх, эрэмбэлэх, үнэлэх, төлөвлөх болон батлах үйл явцын дундуур ТЭЗҮгүй, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг тусгаж хууль болгон батлуулдаг нийтлэг алдаа гардаг болохыг Сангийн яамнаас мэдээлсэн.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг улсын төсөвт тусгуулахдаа өмнө батлагдсан зургийг давтан хэрэглэх, жишиг зураг, нэг маягийн зураг, төсвийг ашиглан улсын төсөвт тусгуулдаг байдлаас хамаарч бодит нөхцөлд нэг маягийн зургийг тухайн төсөл хэрэгжих газар дээр тохируулж, холболт хийх явцад ажлын тоо хэмжээ өөрчлөгдөж, төсөвт өртөг өөрчлөгдөх байдал элбэг тохиолдсон байна.
- 3-аас доошгүй жилийн өмнө хийгдсэн ТЭЗҮ, зураг төсөв ашиглаж тухайн ТАХ-г улсын төсөвт тусгуулдаг байдал нь түүний төсөв өртөг наанадаж инфляцийн нөлөөнөөс хамаарч, цаашлаад голлох түүхий эдийн үнийн өсөлтөөс хамаарч төсөвт өртөг хүрэлцэхгүй болсон байх тул тухайн барилга, байгууламжийн ТАХ-г бүтээн байгуулах явцад төсөвт өртөг дутах эрсдэл үүсдэг байна.

Төсөвт өртөг нь нэмэгдэж буй болон он удаан жил ашиглалтад орохгүй саатсан барилга байгууламжийн талаар Сангийн Яамнаас ирүүлсэн мэдээлэлд асуудлын олон шалтгаан байгааг дурдаж, царцсан гэх ТАХ-нд АТГ болон БХТ-өөс хийсэн мэдээллийг ирүүлсэн байна.

АТГ-аас уг асуудлыг хөндөж 2024 онд Барилгын хөгжлийн төв (БХТ) ТӨҮГ-т хянагдаж байгаа 502 төсөл арга хэмжээнд дүн шинжилгээ хийжээ. Эдгээр төсөл арга хэмжээнүүд 15 жил дамжсан анхны төсөвт өртөг нь 2-оос 5 дахин өссөн барилга ажил үйлчилгээнүүд байна.

Улсын төсөвт зураг төсөл, төсөвгүй, магадлалаар баталгаажуулахгүй, тендер сонгон шалгаруулалтгүй, газрын зөвшөөрөлгүйгээр цэцэрлэг, сургууль, эмнэлэг, дотуур байр, өргөтгөл барих зэрэг төсвийн тооцоо судалгаагүй, үндэслэлгүй, төсөвт өртгийг судлаагүй, түлхүүр гардуулах нөхцөлтэй, төсөвт жил бүр төсөв суулгадаг хэдий ч барилга байгууламж нь баригддаггүй төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж буй нөхцөл байдлууд бодит байдал дээр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 502 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгэхээр захиалагч яамдуудтай БХТ ТӨҮГ гэрээ байгуулсан байна. Үүнээс:

- 2024 он онуудад ашиглалтад оруулсан 29 ТАХ
- Барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байгаа 422 ТАХ
- Барилга угсралтын ажил удаашралтай зогссон болон асуудалтай 51 барилга байгууламж байжээ.

Эдгээрийг ТЕЗ-аар нь хуваарилж үзвэл:

1. Хот байгуулалт, барилга, орон сууц сууцжуулалтын яамны 9 ТАХ
2. Боловсролын яамны 25 ТАХ
3. Эрүүл мэндийн яамны 4 ТАХ
4. Биеийн тамир, спортын улсын хорооны 2 ТАХ
5. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 5 ТАХ
6. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 3 ТАХ
7. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 1 ТАХ
8. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй 1 ТАХ
9. Бусад 1 ТАХ /Өмнөговь аймгийн ГХБХБГ-т эрх шилжсэн/ байна.

Барилга байгууламжийн ажлын гэрээ нь 2010-аас 2022 онуудад байгуулагдсан. Гэрээ хэрэгжиж дуусах огноо нь 2016-2025 онд бөгөөд гэрээгээр 1-2 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр байтал ТЕЗ, гүйцэтгэгч болон зохиогчоос шалтгаалж зогссон байдалтай байжээ.

Царцаж зогссон ТАХ-г нутаг дэвсгэрээр нь авч үзвэл:

- Нийслэлд 4 ТАХ: Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Баянгол дүүргүүдэд
- Орон нутагт 15 ТАХ:
  - Архангай,
  - Булган,
  - Хэнтий,
  - Говь-Алтай,
  - Дархан-Уул,
  - Дорнод,
  - Дундговь,
  - Завхан,
  - Орхон,
  - Сүхбаатар,
  - Өмнөговь,
  - Өвөрхангай, Х
  - өвсгөл,
  - Ховд,
  - Сэлэнгэ аймгуудад гүйцэтгэлийн хувь 0-82%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжээд зогссон ТАХ-үүд байсан.

Зураг төсөлгүй ажлууд хамгийн их батлагддаг салбаруудыг авч үзвэл:

- Боловсрол,
- Эрүүл мэнд,
- Барилга,
- Хөдөлмөр, нийгэм хамгаалал,
- Эдийн засаг
- ХХАА
- Байгаль орчны салбар

Дараах шалтгаанаар ТАХ-ний анх батлагдсан төсөвт өртөг өөрчлөгдөх, гүйцэтгэлийн явцад зогсох шалтгаан бий болдог байна. Үүнд:

- Зураг төсөвгүй, Улсын төсөвт суусны дараа зураг, төсвийг нөхөн хийлгэж магадлалаар оруулдаг.
- Урьдчилан төсвийг тооцоолж хийлгээгүйн улмаас төсөвт өртөг нэмэгдэх байдал бий болдог байна.
- Ингээд дараа жилийн төсөвт дахин нэмэгдэл зардлыг тусгуулан он дамжсан барилгууд бий болдог

Сангийн яамнаас ирүүлсэн зарим ТАХ-ний талаар мэдээлэл

**Жишээ 1: Гүйцэтгэгч компанийн техникийн болон хүний нөөцийн чадамжгүй байдлаас болж ТАХ хэрэгжихгүй саатаж зогссон тохиолдлууд байна.**

**Биеийн Тамир Спортын Улсын Хорооны захиалгатай Спорт цогцолборын барилга**

- Байршил: Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо
- Гэрээ байгуулсан огноо: 2010 он
- Гэрээний дүн: 7.2 тэрбум төгрөг
- Санхүүжүүлсэн дүн: 1.5 тэрбум төгрөг
- Ажлын явц: 40%-тай зогссон
- Гүйцэтгэгч: Үүрэг трейд ХХК

Гүйцэтгэгч талаас шалтгаалсан асуудал: Гүйцэтгэгч байгууллагын зохион байгуулалт ажиллах хүчний чадамжгүй байдал зэргээс шалтгаалж ажил зогссон.

Зохиогч талаас шалтгаалсан асуудал: Барилга барих газар өөрчлөгдсөн тул дахин магадлал хийх шаардлага гарсан.

Төсвийн Ерөнхийлөгчийн захирагч талаас: Барилга барих газар өөрчлөгдсөнтэй холбоотой шинээр зураг төсөв гарган магадлалаар баталгаажсан шинэ зураг төсвөөр ажил гүйцэтгэж байгаа тул захиалагч байгууллага төсвийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсон.

- 2018 оны 8 сард 3.8 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулж газар шороо, суурь, зоорины давхар, 1 болон 2 дугаар давхрын угсралтын ажил гүйцэтгэсэн.

2022 онд 2.2 тэрбум төгрөгийн үлдэгдэл улсын төсөвт суугдаагүй тул ажил зогссон. 2021 онд улсын төсөвт 50 сая төгрөг суусан 2022 онд төсөвт өртгийн нэмэлт гэрээ байгуулж 7.2 тэрбум төгрөгөөр өсөж тухайн онд 1.5 тэрбум төгрөг тусгагдсан. 2022 оны 3 сарын 28-ны байдлаар барилгын ажил эхлээгүй байна.

2024 оны 9-р сарын байдлаар барилгын ажил эхлээгүй байгаа тулд гэрээ цуцлах эсвэл үлдэгдэл хөрөнгийг 2025 оны улсын төсөвт тусгах саналыг захиалагч яаманд хүргүүлэх гэрээг цуцлах саналтайгаар тус тус асуудал хөндөгджээ.

**Жишээ 2. Улсын төсөвт үлдэгдэл хөрөнгө тусгагдаагүй түл ажил зогссон.**

**ЭМЯ-ны захиалгатай Гернотологийн төвийн барилга, дэд бүтэц 60 ортой /Улаанбаатар Хануул дүүрэг/**

- Гэрээ байгуулсан огноо: 2011/ 11/ 28 – 2020/12/
- Гэрээний дүн: 7.3 тэрбум
- Санхүүжүүлсэн дүн: 6.2 тэрбум
- Ажлын явц: 60%-тай зогссон
- Гүйцэтгэгч: Арвис интернэйшнл ХХК

Гүйцэтгэгч талаас: Дутуу ажлын тоо хэмжээтэй ажилд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч байгууллагын зохион байгуулалт, ажиллах хүчний чадамжгүй байдал зэргээс шалтгаалж ажил зогссон.

Зохиогч талаас: Дутуу ажлын тоо хэмжээгээр тендер зарлаж гэрээ байгуулсан. Захиалагч талаас: Гэрээний тоо хэмжээнд тусгагдаагүй үлдэгдэл ажилд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

2023 оны 5-р сарын байдлаар барилгын ажил эхлээгүй байгаа тул гэрээ цуцлах эсвэл үлдэгдэл хөрөнгийг 2024 оны улсын төсөвт тусгах саналыг захиалагч яаманд хүргүүлсэн 2025 оны улсын төсөвт үлдэгдэл санхүүжилтийг тусгуулах саналыг хүргүүлсэн. Улсын төсөвт үлдэгдэл хөрөнгө тусгагдаагүй тул ажил зогссон.

### **Жишээ 3. Дутуу ажлын тоо хэмжээгээр тендер зарлаж гэрээ байгуулсан.**

**Боловсролын яам цэцэрлэгийн барилга 100 ортой. /Хөвсгөл Төмөрбулаг сум/**

- Гэрээ байгуулсан: 2019/10/18 – 2021/12 /31
- Гэрээний дүн: 1 тэрбум төгрөг
- Санхүүжүүлсэн дүн: 377,8 сая төгрөг
- Ажлын явц: 20%-тай зогссон.
- Гүйцэтгэгч: Шидэт гал ХХК

Захиалагч талаас: Боловсролын ерөнхий газраас гэрээг цуцлах шийдвэр ирүүлсэн тул гүйцэтгэгч байгууллагад мэдэгдсэн, гэрээг цуцалсан.

Гүйцэтгэгч талаас: Гүйцэтгэгч байгууллага болох “Шидэт гал” ХХК тодорхой шалтгаангүйгээр ажлыг удаашруулсан.

### **Жишээ 4: Төсөвт өртөг өссөн үзүүлэлт**

Хөвсгөл, Төмөрбулаг сум, Цэцэрлэгийн барилга тэнхлэгээрээ 24 метр 24-ийг харьцах нь 19.8 метр, 2 давхар зоорьгүй, 100 ортой

- Гэрээний дүн нь 1.29 тэрбум төгрөг.
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

МҮОНРТ орчмын хорооллын 6 хэсгийн 6 ширхэг ус дулаан дамжуулах төвийн барилга гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, барилга угсралтын ажил.

- Гэрээ байгуулсан огноо: 2016/11/1- 2018/11/25
- Гэрээний дүн: 1.6 тэрбум
- Санхүүжүүлсэн дүн: 502.6 сая төгрөг.
- Ажлын явц: 30%
- Гүйцэтгэгч: Ви Ти Икс ХХК.

Захиалагч талаас: Улаанбаатар хот. Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо ЧД-ийн 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт МҮОНРТ орчмын гэр хорооллийг орон сууцжуулах, хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэгчээр “Эрэл” ХХК шалгарсан байдаг.

Ус дулаан дамжуулах 6 ширхэг төв барихаас 4 ширхэг нь архитектур төлөвлөлтийн даалгаваргүй газар чөлөөлөлт хийгдээгүй байна.

Улс улаан дамжуулан түгээх 2-ын барилга, тоног төхөөрөмж, угсралтын ажилд 2017 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байнгын ашиглалтад оруулах урьдчилсан дүгнэлт гаргах комисс, 2017 оны 12 сарын 14-нд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулж хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын 2019, 2020 оны төсвийн тухай хуульд хөрөнгө тусгагдаагүй.

Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 07/1118 дугаартай албан бичгээр шинээр ус, дулаан хуваарилах төв, дамжуулах болон түгээх сүлжээний шугам барих боломжгүй тухай ирүүлсэн. Мөн баригдсан ус дулаан дамжуулах төв номер нэгийг Улсын комисс ажиллуулж хэр хэрэглэгч холбоход бэлэн болгон хүлээлгэн өгөх шаардлагатай тухай ирүүлсэн.

Иймд энэ төсөл арга хэмжээний үлдэгдэл ажлын талаар БХБЯ-д албан бичиг хүргүүлж, тус яам 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж ажил гүйцэтгэх гэрээг сунгах, гэрээнд өөрчлөлт оруулах, ус, дулаан дамжуулах 1 дүгээр төвийн хэрэглэгч холбогдож төсөвт хөрөнгө төлөвлөсөн үед гэрээг дуусгавар болгохоор шийдвэрлэсэн. Гэрээний төсөл холбогдох материалуудыг БХБЯ-нд хүргүүлсэн гэжээ.

Хүснэгт 1.2. УАГ-аас ирүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч, зогссон төслийн мэдээлэл (Тэрбум төгрөг)

№	ТЭЗ	ТАХ-ний нэр	Байршил	Эхэлсэн он	Гүйцэтгэлийн хувь	Гүйцэтгэгч	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
1	ССАЖЗС	ХУД 4-Р хороо 1000 спорт суудалтай цогцолборын барилга	УБ, ХУД	2010	40%	Үүрэг трейд ХХК	7,280.1	3,306.9
2	ЭМС	Гернотологийн төвийн барилга дэд бүтэц 60 ор	УБ, ХУД	2011	60%	Арвис интернэшнл ХХК	7,392.9	6,216.4
3	ЭМС	50 ортой төрөх эмнэлэг	Дундговь, Сайншанд сум	2011	40%	Мон инж бар ХХК	1,817.9	7,665.0
4	ССАЖЗС	Соёл спортын цогцолбор	Дундговь, Замын-Үүд сум	2013	45%	Фронт гейт ХХК	5,844.1	3,426.7
5	БС	Цэцэрлэгийн барилга 100 ор	Сэлэнгэ, Мандал сум	2014	73%	Талын Монгол гуул ХХК	732.9	678.2
6	ХББОСС	Сумын төвийн шинэчлэл төсөл	Говь-Алтай, Дэлгэр сум	2014	60%	Мандал голомт ХХК	5,000.0	2,607.3
7	ССАЖЗС	Дүүргийн спортын цогцолборын барилга 1000 суудал	УБ, СБД	2015	45%	Грийн ресурс ХХК	7,219.0	4,672.0
8	ХББОСС	МҮОНРТ орчмын хорооллын 6 хэсгийн 6 ширхэг ус дулаан дамжуулах төвийн барилга гадна цахилгаан хангамжийн зураг төсөл барилга угсралтын ажил.	УБ, ЧД	2016	30%	Эрэл ХХК	1,633.0	520.7

9	ХББОСС	Дэнжийн орчмын хороололын инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил.	1000	УБ, ЧД 10, 11 дүгээр хороо	2017	98%	Энерготех сервис ХХК	3,976.3	3,295.5
10	БС	Сургуулийн барилга 320 суудал		УБ, СХД 31-р хороо	2018	90%	Глобалрост ХХК	4,271.6	0
11	БС	Сургуулийн барилга өргөтгөл 640 суудал		УБ, СХД 62 дугаар сургууль	2018	85%	Ганзосон ХХК	5,934.0	5,340.6
12	БС	Цэцэрлэгийн барилга 240 ор		УБ, ХУД 14-р хороо	2018	65%	Хангайн хятруун ХХК	1,750.0	849.1
13	БС	Сургуулийн барилга 320 суудал		Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум	2019	80%	Хөвсгөл суврага ХХК	3,496.6	3,496.5
14	СОЁЛИЙН САЙД	Музейн барилга		Дорнод, Хэрлэн сум	2019	70%	Сүхжин ХХК	4,478.5	3,629.3
15	БС	Дотуур байрны барилга 150 ор		Дорнод, Цагаан овоо сум	2019	85%	Өндөр баганат ХХК	1,963.5	1,399.4
16	ХББОСС	Үерийн далан		УБ, СБД	2019	95%	Шимт газар ХХК	2,632.4	2,632.4
17	БС	960 хүүхдийн сургуулийн барилга		Өмнөговь, Цогтцэций сум	2019	25%	Грийн ресурс ХХК	6,713.6	1,773.1
18	ССАЖЗС	Соёлын төвийн барилга 250 суудал		Орхон, Баян-Өндөр сум	2019	65%	Аминхүү констракшин ХХК	1,000.0	1,449.0
19	БС	Жавхлантай цогцолбор сургуулийн 2 дугаар байрны барилга завхан улиастай сум		УБ, ХУД	2019	95%	Бэрсүм ХХК	4,475.8	4,083.2

20	ЗТХС	Сумын төвийн хатуу хучилттай авто зам 3км	Завхан, Их-Уул сум	2019	70%	Пирамид проект ХХК	2,025.0	-
21	БС	Цэцэрлэгийн барилга 75 ор	Говь-Алтай, Алтай сум	2019	15%	Си Би Ай аутсорс ХХК	865.3	-
22	ССАЖЗС	Соёлын төвийн барилга 150 суудал	Говь-Алтай, Тонхил сум	2019	30%	Уран охид ХХК	1,502.2	1,972.0
23	БС	Цэцэрлэгийн барилга 200 ор	УБ, СХД 22-р хороо	2019	88%	Татах хүч ХХК	2,794.2	-
24	БС	Дотуур байрны барилга 120 ор	Архангай, Өгийнуур сум	2019	95%	Хатант констракшин ХХК	1,616.4	1,616.4
25	БС	Цэцэрлэгийн барилгын их засвар Янзагахан цэцэрлэг	Сэлэнгэ, Мандал сум хэрх тосгон	2020	50%	Эрдэнэт констрактив ХХК	238.0	238.0
26	БС	Цэцэрлэгийн барилгын их засвар 1-р цэцэрлэг	Сэлэнгэ, Мандал сум	2020	50%	Оргил таун констракшин ХХК	179.4	179.4
27	БС	Сургуулийн барилга 320 суудал	Архангай, Хайрхан сум	2020	75%	Эртний цамхаг констракшин ХХК	3,723.8	3,723.8
28	БС	Сургуулийн барилга 640 суудал	Дорнод, Хэрлэн сум	2020	20%	Шимт газар ХХК	5,438.9	-
29	ССАЖЗС	Соёлын төвийн барилгын их засвар	Говь-Алтай, Хөхмөрүт сум	2020	50%	Аранжин алтай ХХК	219.9	219.9
30	ССАЖЗС	Соёлын төвийн барилга 200 суудал	Завхан, Нөмрөг сум	2020	70%	Ар Си Ди интернэшл ХХК	1,567.4	1,567.4
31	БС	Дотуур байрны барилга 75 ор	Завхан, Асгат сум	2020	40%	Эко энержи ресурс ХХК	1,262.2	1,262.2

32	БС	Хүүхэд хөгжил, хамгааллын төвийн барилга	Орхон, Баян-Өндөр сум	2020	30%	Ээлт-Өлгий ХХК	1,742.0	1,742.0
33	БС	Сургуулийн барилга 240 суудал	Баянхонгор, Баянхонгор сум Шаргалжуут 8-р баг	2020	60%	Очир заан ХХК	2,196.2	-
34	БС	Цэцэрлэгийн барилгын их засвар	Ховд, Булган сум	2020	80%	Хартаны ус ХХК	0.0	-
35	БС	Цэцэрлэгийн барилгын их засвар 3 дугаар цэцэрлэг А байр	Сэлэнгэ, Сүхбаатар сум	2021	85%	Ганхөлөг констракшин ХХК	0.0	440.7
36	БС	Дотуур байрны барилга	Говь-Алтай, Тайшир сум	2021	30%	Чингисийн констракшин ХХК	81.0	-
37	ХББОСС	Сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил	Дундговь, Сайхан-Овоо сум	2021	50%	Эхлэл шинэчлэл прожект ХХК	1,814.4	949.9
38		Соёлын төвийн барилга 300	Хэнтий, Цэнхэрмандал сум	2021	0%	Дарви өргөө ХХК	1,855.0	2,900.4
39		Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Архангай, Ихтамир сум	2022	95%	Тамир таун ХХК	1,499.9	1,499.9
40		Спорт заалны барилга 240 суудал	Ховд, Дарви	2020	40%	Богочконстракшин ХХК	1,300.0	0
41		Спорт заалны барилга 240 суудал	Ховд, Цэцэг	2021	70%		1,300.0	0

## **1.2. Төсвийн төлөвлөлтөд санал авах, эрэмбэлэлт, батлах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үйл явц, түүний мэдээлэл нь шийдвэр гаргах түвшинд ил бус байгаа асуудал**

Улсын төсвийг анх төлөвлөхөд санал авахаас эхлэн батлах, хэрэгжүүлэх бүхий л үйл явц нь хоорондоо уялдаатай, оролцогч болон шийдвэр гаргах талуудад нээлттэй, ил тод бөгөөд үйл явцад хөндлөнгөөс нөлөөлөх боломжгүй байх зарчмууд баримтлагдаж байж төсвийн төлөвлөлт нь үр ашигтай батлагдах боломжтой гэж харж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам<sup>1</sup>-д “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, тэдгээртэй холбогдсон харилцаанд энэ журмыг баримтлах”-аар заасан байдаг.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээний эргэн төлөлт, төсвөөс санхүүжих төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл, арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад энэ журмыг мөрдлөг болгоно.

Гэвч энэ үйл явцад төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ТАХ-г хэлэлцэн батлах үйл явц энэ журамд хамаарахгүй бөгөөд УИХ-ын бүрэн эрхийг ЗГ-ын журмаар зохицуулахгүй гэж үзсэнтэй холбоотой байх. Тиймдээ ч УТХО-аар санхүүжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад цахим систем ашиглахаар уг журамд заасан байдаг.

Энэ журмын 1.5-д зааснаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29<sup>1.4</sup>-т заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр хэрэгжүүлнэ.

УИХ-ын гишүүд улсын төсвийг хэлэлцэн батлахдаа энэхүү цахим системийг ашигладаг боломжийг бүрдүүлж, улмаар төсвийг хэлэлцэн батлахдаа Үндсэн хууль болон Төсвийн тухай хуулийг баримталдаг байх зохцуулалтыг ч бид хийх шаардлага үүсч байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хоринтав дугаар зүйлийн 7-д “Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно” гэж заасны дагуу зарчмын зөрүүтэй санал гаргах бол төсвийн орлого зарлагын бүтцийг өөрчилж болдог. УИХ-аар улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Төсвийн хэлэлцүүлгийн 3 дахь үе шатад “төсвийн төслийн гурав дахь

---

<sup>1</sup> Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралт

хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах<sup>2</sup> хэсэгт ТАХ-г тусгахдаа цахим системд байршиж, үнэлгээний дагуу өндрөөр эрэмбэлэгдсэн ТАХ-ээс сонгох боломжгүй байгаа нь асуудал дагуулж байна. Нэг талаас УИХ болон ЗГ-ын үйл ажиллагаа, чиг үүрэг өөр тул ЗГ-ын баталсан журмаар УИХ-ын төсөв батлах онцгой эрхийг хязгаарлах боломжгүй, нөгөө талаас УИХ-ын гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлж ТАХ-г улсын УТХО-аар санхүүжүүлэхдээ ЗГ-ийн хэмжээнд бэлтгэсэн төсвийн төслийн цаана буй үнэлгээ авч эрэмбэлэгдсэн төслүүдийн талаарх мэдээлэл хомс байдалтай холбоотой юм.

Мөн тухайн жилийн 6-р сарын 1-ээс өмнө дараа жилийн Улсын хөгжлийн төлөвлөгөөг УИХ-аар баталж буй бөгөөд УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-г улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд эхэлж тусгасан байх зохицуулалтыг хуульд тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна. Мөн УИХ-ын гишүүдийн бүрэн эрхийн хүрээнд ТАХ-ны санал гаргахдаа сонголт хийх ТАХ-г цахим системд эрэмбэлэгдсэн ТАХ-ээс сонгох нөхцөлийг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

### 1.3. Үнэлгээ хийх хүрээ

Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээг Монгол Улсын 2024, 2025, 2026 оны төсвийн төлөвлөлт дэх УТХО-ын тоон мэдээлэлд бичиг баримтын судалгаа, тооцоолол, тоон харьцуулалтын арга ашиглан хэрэгжүүлнэ. Үүнд:

Хүснэгт 1.3. УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээ (оноор)

УТХО-ийн төсөл арга хэмжээ		2024	2025	2026
УТХО-ын нийт төсөл арга хэмжээ	Тоо	1,319	639	579
	Анхны төсөвт өртөг. сая.төг	4,082,097	6,502,096	6,205,278
	Сүүлийн төсөв сая.төг	11,516,391	12,134,006	9,631,880
	Тухайн жилийн санхүүжих дүн. сая.төг	3,765,314	4,145,615	3,267,318


**2024 онд УТХО-аар нийт 1319 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.**

Хүснэгт 1.4. 2024 онд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний (тоо төрлөөр)

	ТАХ-ны төрөл	ТАХ-ын тоо
1	Барилга, байгууламжийн ТАХ	1020
2	Их засварын ТАХ	48
3	Тоног, төхөөрөмжийн ТАХ	235
4	ТЭЗҮ, зураг төсвийн ТАХ	16

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.3.

График 1.1. 2024 онд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний (тоо төрлөөр)




**2025 онд УТХО-аар нийт 639 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.**

Хүснэгт 1.5. 2025 онд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний (тоо төрлөөр)

	ТАХ-ны төрөл	ТАХ-ын тоо
1	Барилга, байгууламжийн ТАХ	555
2	Их засварын ТАХ	22
3	Тоног, төхөөрөмжийн ТАХ	53
4	ТЭЗҮ, зураг төсвийн ТАХ	9

График 1.2. 2025 онд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний тоо (төрлөөр)




**2026 онд УТХО-аар нийт 579 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.**

Хүснэгт 1.6. 2026 онд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний (тоо төрлөөр)

	ТАХ-ны төрөл	ТАХ-ын тоо
1	Барилга, байгууламжийн ТАХ	489
2	Их засварын ТАХ	14
3	Тоног, төхөөрөмжийн ТАХ	71
4	ТЭЗҮ, зураг төсвийн ТАХ	5

График 1.3. 2026 онд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний (тоо төрлөөр)



#### 1.4. Шалгуур үзүүлэлт

Энэхүү судалгааны шалгуур үзүүлэлтийг бид тооцоолохдоо тухайн ТАХ-ны хувьд Их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ-ийн хэлбэрийн ТАХ-ын хувьд тухайн жилдээ, харин барилга байгууламжийн ТАХ-ын хувьд 3-н жилийн хугацаанд баригдаж ашиглалтад орох ёстой гэсэн шалгуур тавьж байна.

Хүснэгт 1.7. Сүүлийн 3-н жилд УТХО-аар батлагдсан төсөл арга хэмжээний анх батлагдсан (он тоогоор)

ТАХ анх батлагдсан он	3 жилийн хязгаар	Хугацаа хэтэрсэн жил	Хугацаа хэтэрсэн ТАХ-ны тоо
2010	2013	13	2
2011	2014	12	4
2012	2015	11	4
2013	2016	10	4
2014	2017	9	5
2015	2018	8	1
2016	2019	7	0
2017	2020	6	0
2018	2021	5	23
2019	2022	4	71
2020	2023	3	97
2021	2024	2	99
2022	2025	1	174

Монгол Улсын 2024-2026 оны төсвийн УТХО-ийн ТАХ-нд боловсруулалт хийж, анх батлагдсан төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ-г он дамжиж төсөв нь хуваарилагдсаныг шүүж давхцалыг арилгаж үзэхэд нийт 522 төсөл арга хэмжээ байна. Үүнээс 2018 оноос хойших төсөл арга хэмжээний хувьд анх батлагдсан төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ-ны тоо хурдтай өссөн нь харагдаж байна.

## 1.5. Харьцуулах хэлбэр

УТХО-ын ТАХ-нд тооцоолол хийхдээ бид дараах харьцуулалтаар боловсруулалт хийж үзлээ.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцаар,
- ТАХ хэрэгжих засаг захиргааны нэгжээр,
- ТАХ анх батлагдсан оноор,
- УТХО-ын хавсралт болох 2024, 2025, 2026 оны төсвийн төслөөр
- ТАХ-ны хэлбэр зэргээр харьцуулалт хийв.

Шалгуур үзүүлэлтийг гаргахдаа тухайн ТАХ нь 3 жилийн дотор баригдаж дуусан хүлээлгэн өгсөн байхаар томьёолж, түүнээс илүү хугацаа хэтэрсэн ТАХ нь төсөвт тавигдах хугацааны шаардлагыг хангаагүй гэх байдлаар томьёолж үзэв.

Мөн шалгуур үзүүлэлтэд дараах нөхцөлүүдийг тусгасан болно. Үүнд:

- ТАХ нь УТХО-аар санхүүжихээр батлагдах үедээ ТЭЗҮ, зураг төсөвгүй байсан эсэх,
- ТАХ нь УТХО-аар санхүүжихээр батлагдах үедээ жишиг зураг төсөв ашигласан эсэх,
- Бусад.

Барилгын Хөгжлийн Төв /БХТ/-өөс “Төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналын дагуу ямар процесс явагддаг, ямар журам, эрх зүйн зохицуулалтын хүрээнд төсөв өртгийг нь нэмэгдүүлэхээр төсөвт тусгадаг шалтгаан”-ыг дараах байдлаар тайлбарлаж байна.


Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “Барилгын материалын үнэ болон ханшны өөрчлөлт, бусад хүчин зүйлээс хамааран барилга байгууламжийн төсвийн тооцоонд өөрчлөлт оруулах тохиолдолд санхүү, эдийн засгийн болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран үндэслэл, тооцоог хянаж, санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заасны дагуу анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдсөн төсөл арга хэмжээний төсөвт өртөг өөрчлөгдөх үйл явц нь Зураг ...-д заасны дагуу явагддаг. Үүнд:

Гүйцэтгэгч барилгын явцад бий болсон асуудлаас хамаарч төсөв өртөг хүрэхгүй болсон тохиолдолд ТЕЗ болон төслийн захиалагчид хандах бөгөөд ТЕЗ-аас БХТ-д тухайн төсөвт орхигдсон тоо хэмжээ, техникийн шийдэл, тоо хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой нягтлах ажиллагаа хийдэг. Үүний дараа зураг төслийн мэргэжлийн байгууллагад төслийн гүйцэтгэгч компани хандсаны дагуу зохих нэмэлт өөрчлөлт хийгдэж боловсруулсан зураг БХТ-д ирж хянагдаж магадлал хийгдэнэ.

Ингээд магадлал хийгдсэн зураг, төсөв ТЕЗ руу, ТЕЗ нь Аудитын байгууллага руу илгээж дүгнэлт гаргуулна. Ингээд ТЕЗ нь Аудитын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн оны төсөвт тусгуулахаар СЯ-нд санал хүргүүлнэ.

Ингэхдээ, БХТ нь Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, 25 дугаар зүйлийн 25.5-ийг тус тус үндэслэж магадлал хийдэг байна.

Зураг Төсөл арга хэмжээний анх батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлэх саналын дагуу явагддаг процесс



Эх сурвалж: Барилгын Хөгжлийн Төв

## **1.6. Мэдээлэл цуглуулах арга**

Судалгаанд мэдээллийг цуглуулах дараах аргыг ашиглав. Үүнд:

А. Бичиг баримтын судалгааны аргаар Монгол Улсын нэгдсэн төсвийн сүүлийн 3 жилийн мэдээллийг ашиглав.

1. 2024, 2025 оны батлагдсан Улсын төсвийн файлыг d.parliament.mn-ээс авч ашиглав.
2. Монгол Улсын 2026 нэгдсэн төсвийн төслийн 2-р хавсралтад буй УТХО-ийн жагсаалт

Б. АЕГ-аас 2023, 2024 онуудын улсын төсвийн гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

В. СЯ- аас ирүүлсэн холбогдох тоон мэдээлэл зэрэгт боловсруулалт хийж үзлээ.

Г. БХТ-өөс ирүүлсэн мэдээлэл

Хэлэлцүүлэг өрнүүлж мэдээлэл цуглуулах

1. Гүйцэтгэгч компаниудын хүрээнд: УТХО-аар санхүүжүүлсэн ч царцсан ТАХ-г хэрэгжүүлэгч байгууллагуудын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, эрх ашиг нь хөндөгдөж буй гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн санал, дүгнэлтийг сонсох

## Хоёр. УТХО-ААР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭЖ БҮЙ БАЙДЛЫН СУДАЛГАА

### 2.1. Монгол Улсын 2024, 2025, 2026 оны төсөвт тусгагдсан УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хийсэн судалгаа, Үндэсний аудитын газрын дүгнэлт

#### 2.1.1. УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ❖ Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байгаа нь өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах шалтгаан болж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 10, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 1129, нийт 7,376.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1139 төсөл, арга хэмжээг 2,686.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байдаг.

2023 оны төсвийн нийт санхүүжилтийн 75.4 хувийг барилга, байгууламж, 18.3 хувийг тоног төхөөрөмж, 4.1 хувийг их засвар, 2.2 хувийг ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

*Хүснэгт 2.1. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (сая төгрөг)*

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	3	228,875.7	118,033.1	977	6,152,070.2	1,907,550.5	980	6,380,945.9	2,025,583.6
Их засвар	2	35,885.5	35,885.5	69	149,643.0	72,808.3	71	185,528.5	108,693.8
Тоног төхөөрөмж	4	366,079.3	320,299.4	67	362,618.7	171,471.1	71	728,698.0	491,770.5
ТЭЗҮ	1	40,000.0	40,000.0	16	41,072.6	19,967.4	17	81,072.6	59,967.4
<b>Нийт</b>	<b>10</b>	<b>670,840.5</b>	<b>514,218.0</b>	<b>1129</b>	<b>6,705,404.5</b>	<b>2,171,797.3</b>	<b>1139</b>	<b>7,376,245.0</b>	<b>2,686,015.3</b>

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар 1369 ТАХ-ний санхүүжилтэд 1,393.8 тэрбум төгрөг төлөвлөсөн бол 2023 онд 1139 ТАХ-нд 2,686.0 тэрбум төгрөг олгохоор төлөвлөж, санхүүжилт өмнөх онтой харьцуулахад 51.9 хувиар өссөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1139 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 77.5 хувь буюу 883 төсөл, арга хэмжээг 2023 онд, 22.5 хувь буюу 256 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Тухайн оноос хэрэгжиж эхлэх 60.3 тэрбум төгрөгийн 67 төсөл, арга хэмжээтэй холбоотой эрх шилжүүлэх шийдвэрийг холбогдох журамд заасан хугацаанд гаргаагүй, хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, хуулиар баталсан

ангилалд хамаарахгүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ЭЗХС улсын хэмжээнд хэрэгжүүлэх 40.0 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ТАХ-ын багцын задаргааг батлах, эрх шилжүүлэх шийдвэрийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журмын 2.1.7<sup>3</sup>, 2.2.2<sup>4</sup>-д заасан хугацаанаас хоцорч 2023 оны 07 дугаар сарын 27-нд гаргаснаас шалтгаалан 15.2 тэрбум төгрөгийн зураг, төсөл боловсруулах 50 ажлын гэрээ 8-12 дугаар сард байгуулагдсанаар тухайн онд хэрэгжих боломжгүй болж дараа онд шилжсэн;
- МУСНУБХТБҮХД-аас Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний 37.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автопарк багцын үнэлгээний хороо тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан;
- Сангийн сайдын багцын “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах” /Улсын хэмжээнд/ ТАХ-ний 18.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс 23 хувийг буюу 4.1 тэрбум төгрөгийг батлагдсан “барилга байгууламж” ангилалд хамаарахгүй БОАЖС, ЕТГД, Дархан-Уул аймгийн Засаг даргын төсвийн багцын нийт 8 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журмын 4.1.33<sup>5</sup> дахь заалтад нийцээгүй;
- БШУС-ын багцын 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Эрдэнэт Шинжлэх ухаан технологийн паркийн ТЭЗҮ /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-г Орхон аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулалтын ангиллыг зөрүүлж, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр барилга барих, тоног төхөөрөмж худалдан авах тендер зарлаж гэрээ байгуулсан ба ажлын даалгаврыг дахин боловсруулаагүй, шаардагдах зардал, төсвийг тооцоогүйгээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 1.7 тэрбум төгрөгөөр ТЭЗҮ

---

<sup>3</sup> 2.1.7. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн задаргааг холбогдох шийдвэрийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ”

<sup>4</sup> 2.2.2. “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төвбайгууллагад хүргүүлнэ”

<sup>5</sup> 4.1.33. “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно”

хийлгэхээр шийдвэрлэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 36.1<sup>6</sup>, 36.3<sup>7</sup>, 36.4<sup>8</sup>, 8.2<sup>9</sup>, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан үнэлгээний хорооны журмын 4.10, 4.119 дэх заалтыг тус тус зөрчсөн байжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын 5 төсөл, арга хэмжээнээс 3 нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байжээ. Үүнд:

- НУБХАЗТБҮХД-ын багцын 45.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгосон байх шаардлагыг хангаагүй;
- НУБХАЗТБҮХД-ын багцын 45.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ нь төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй;
- ХНХС-ын багцын 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Өнөр бүл хүүхдийн төвийн их засварын ажил зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байхад төсөвт тусгасан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.410, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.211, 3.2.3.412-т заасан шаардлагыг хангахгүй байна.

Жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталж байгаа нь түлхүүр гардуулах нөхцөлөөр тендер зарлах, батлагдсан төсөвт тааруулан ажлын тоо хэмжээг багасгах, барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, тохижилтын ажил иж бүрэн хийгдэхгүй орхигдох, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хүлээж хугацаа алдах зэргээр төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх хүндрэлийн суурь шалтгаан болж байна гэж АЕГ-аас дүгнэжээ.

СЯ-ны мэдээллээс харахад УТХО-аар санхүүжүүлж буй ТАХ-ний төсөвт өртөг өөрчлөгдөж, царцаж гацсан нь дараах шалтгаантай байна.

- ✓ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж эхлээд дуусаагүй орхигдсон 184.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 59 төсөл арга хэмжээг 85

---

<sup>6</sup> 36.1. “Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэнэ”

<sup>7</sup> 36.3. “Захиалагч шаардагдаж байгаа үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна”

<sup>8</sup> 36.4. “Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дараа зөвлөхийн жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэлд нийтэлнэ”

<sup>9</sup> 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”

тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. Эдгээр ТАХ нь төсвийн хөрөнгөөр 2008-2020 онд хэрэгжүүлж эхэлсэн дуусаагүй орхигдсон

- ✓ Аудитын судалгаагаар илэрсэн, орхигдсон эдгээр 59 барилга байгууламжийн ихэнх нь буюу 32.2%-ийг цахилгаан, дулаан инженерийн байгууламж эзэлж байсан байна.

Аудитын Ерөнхий Газар “Улс орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитыг 2022 онд хийсэн.

*Хүснэгт 2.2. Төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ-ыг нэр төрлөөр ангилсан байдал*

ТАХ-ны нэр төрөл, бүлгээр	Нэмэгдсэн төсөв	Эзлэх хувь
Дулаан, цахилгаан, инженерийн шугам сүлжээ	57.1 тэрбум төгрөг	32.2%
Нийгэм соёл үйлчилгээний	25.5 тэрбум төгрөг	30.5%
Сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөл	13.1 тэрбум төгрөг	16.9%
Үйлдвэрлэл үйлчилгээ	88.8 тэрбум төгрөг	20.3%

Эх сурвалж : СЯ-наас ирүүлсэн мэдээлэл

МХЕГ-аас ирүүлсэн мэдээллээр 2016-2021 онд хамгаалалтын горимд шилжүүлсэн 13 барилга байсан бөгөөд орхигдсон барилгаас зөвхөн нэг барилга буюу Сэлэнгэ аймгийн Мандал суманд баригдаж буй 100 ортой цэцэрлэгийн барилгыг хамгаалалтын горимд авсан.

УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээ нь ялангуяа барилга байгууламжид төлөвлөлтийн үе шатаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэл хугацаанд хяналт тавих нэгдсэн систем “цахим сис” сан байхгүйгээс төсөл, арга хэмжээ дутуу орхигдох, хаягдах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх байдал байна.

Барилга угсралтын ажлын гүйцэтгэлд тавих мэргэжлийн байгууллага захиалагч зохиогчийн хяналт хангалтгүйгээс барилга угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэх, дуусгалгүй орхих, данс бүртгэлд тусгаагүй байх зэргээр хөрөнгө эзгүйдэх чанар байдал нь ашиглалтын шаардлага хангахгүй байх. Барилга байгууламжийг төлөвлөхөөс ашиглалтын хугацаа дуусах хүртэл хугацаанд хяналт байхгүй байхгүй байсаар иржээ.

### Дүгнэлт

1. Олон жил дамнасан асуудал нь зураг, төсөлгүй, төсөвт өртгийг таамгаар боловсруулснаас санхүүжилт дутах;
2. Зургийг магадлалаар баталгаажуулаагүй;
3. Төлөвлөлт, бүртгэл, ажил төлөвлөлт, бэлтгэл ажил хангалтгүй;
4. Худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулдаггүй эсвэл захиалагч тал гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн явцад тухай бүр хяналт тавьдаггүй;
5. Барилга угсралтын ажил болон захиалагч, гүйцэтгэгч компаниудын явцын хяналт дотоод зохион байгуулалт хангалтгүй;
6. Норм стандартыг хангадаггүй;
7. Газар чөлөөлөлтийг шийдвэрлээгүй;

8. Гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлдэггүй;
9. Төлөвлөлт муугаас жил бүрийн улсын төсөвт санхүүжилт тусгуулдаг;
10. Барилгын ажил 90%-ийн гүйцэтгэлтэй боловч зарим үе шатын ажлууд дутуу батлагдсан. Зураг төсөл норм ба дүрмийн дагуу хийгдээгүй дахин засварлах засварлаж хийх шаардлагатай;
11. Гэрээг цуцалдаг;
12. Үлдэгдэл ажлын тоо хэмжээг үндэслэн шинэчилсэн төсөв гаргуулдаг зэрэг шалтгааныг СЯ-наас ирүүлсэн мэдээлэлд дурдагджээ.

### 2.1.2. ТАХ-НЫ ТӨСӨЛТ ӨРТӨГ ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ҮНДСЭН ШАЛТГААНУУД

БХТ-өөс ирүүлсэн мэдээллээс харахад УТХО-аар өмнө батлагдсан ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх дараах хэд хэдэн үндсэн шалтгаан байна. Үүнд:

Үүнд дараах нөхцөлүүд үүсч, нэмэлт зардал гарна.

*Хүснэгт 2.3. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх шалтгаан 1*

1	Нэг маягийн зураг төсөл /холболт/	<ul style="list-style-type: none"> <li>• Байршил /тээврийн зардал, инженер геологийн судалгаа,/</li> <li>• ГИШС-ний шийдэл</li> <li>• Төхижилын ажил /тоног төхөөрөмж/ гэх мэт ажлын төсөв нэмж тооцогдох шаардлагатай</li> </ul>
2	Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ	Батлагдсан зураг төсөлгүйгээр улсын төсөвт санхүүжилт суулгаж тендер зарлаж гэрээ байгуулсаны дараа зураг төсөл, төсөвт магадлал хийлгэдэг.
3	Нэмэлт ажил	Захиалагчийн хүсэлтээр зураг төсөл, төсөвт тусгагдаагүй ажлуудад нэмэлтээр магадлал хийлгэх
4	Өөрчлөлтийн ажил	<ul style="list-style-type: none"> <li>• Зураг төслийн даалгавар</li> <li>• Техникийн нөхцөл</li> <li>• Байршил</li> <li>• Үндсэн хийц бүтээц зэрэг нь өөрчлөгдсөнөөс БТХ 25.5-д заасны дагуу дахин магадлал хийлгэдэг.</li> </ul>
5	Тоо хэмжээ хасаж тендер зарлах	Захиалагч батлагдсан тоо хэмжээг хасаж тендер зарлаж улсын төсөвт суулгасны дараа үлдэгдэл ажилд дахин магадлал хийлгэдэг.

#### **Шалтгаан 1: Холболтын зураг төслийг батлуулахгүйгээр нэг маягийн зураг төслөөр тендер зарлах**

Үүний суурь шалтгаан нь УИХ дээр УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээг батлахад нэг маягийн зураг төсөл ашигласан ТАХ-г төсөвт суулгаж баталснаас үүдэлтэй. Үүнд дараах 2 үндсэн шалтгаанаар холболтын зураггүй нэг маягийн зураг төсөв улсын төсөвт тусгагддаг. Үүнд:

Нэгдүгээрт, ЗГ-аас оруулж ирсэн ТАХ-ны жагсаалт дотор нэг маягийн зураг төсөв ашигласан ТАХ-нүүдийг олноор тусгасан байдаг.

Хоёрдугаарт, УИХ-аар улсын төсвийг хэлэлцэх батлах үед УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-ны жагсаалтын бүтцийг өөрчилж зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор ТАХ-г оруулж ирэхдээ холболтын зураггүй төсөл нэг маягийн зураг төсөв ашигладгаас хамаарч уг ТАХ-ны тендер батлагдсан байдлаар нэг маягийн зургаар тендер зарлагдаж, улмаар шалгарсан компани нь бодит байдал дээр холболт хийх шаардлага тулгарахад төсөвт өртөг хүрэлцэхгүй шалтгаан бий болдог.

Жишээ: ТАХ-ны нэр: XII.1.1.54 кодтой, 150-н хүүхдийн цэцэрлэгийн барилга /Баян-Өлгий, Улаанхус/

Хүснэгт 2.4. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх шалтгаан 2

ТАХ-ны нэр	Огноо	Төсөвт өртөг. сая төгрөг
Зураг төсөл магадлал хийгдсэн	2021.06.29	2,882.0
Улсын төсөв анх суусан огноо, анх батлагдсан төсөвт өртөг	2022	2,882.0
Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан	2022.02.02	2,882.0
Зураг төслийн магадлал /Холболт/ +Тээвэр, ГИШС, тоног төхөөрөмж, зураг төслийн үнэ	2022.11.11	3,586.0
Төсөвт өртгийн зөрүү		704.0

#### Шалтгаан 2. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ

Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээгээр барилга, байгууламжийн ТАХ-г баталж, тендер зарласны дараа гүйцэтгэлийн явцад тухайн ТАХ-ны төсөв өртөг нь нэмэгддэг. Үндсэн хийц бүтээц зэрэг нь өөрчлөгдөх, улмаар тоног төхөөрөмжид ч үнийн өөрчлөлт гарсан байдаг. Иймд Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д заасны дагуу дахин магадлал хийлгэдэг.

Жишээ 2: XIII.1.1.235 кодтой, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл 100 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо/

Хүснэгт 2.5. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх шалтгаан 3

ТАХ-ны нэр	Огноо	Төсөвт өртөг. сая төгрөг
Улсын төсөв анх суусан огноо, анх батлагдсан төсөвт өртөг	2021	1,261.0
Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан	2021.12.20	1,261.0

Зураг төслийн магадлал	2022.12.23	3,734.0
<b>Төсөвт өртгийн зөрүү</b>		<b>2,473.0</b>

Шалтгаан 3. Батлагдсан зураг төсөлгүйгээр улсын төсөвт санхүүжилт суулгаж тендер зарлаж гэрээ байгуулсаны дараа зураг төсөл, төсөвт магадлал хийлгэдэг

Төсөл арга хэмжээг ЗГ-аас оруулж ирсэн төсвийн төсөлд батлагдсан зураг төсөвгүй ТАХ-ыг тусгаж оруулж ирдэгба мөн УИХ дээр зарчмын зөрүүтэй гаргасан саналд батлагдсан зураг, төсөвгүй ТАХ-г тусгаж улсын төсөвт санхүүжилт суулгаж, улмаар тендер зарлаж гэрээ байгуулсны дараа зураг төсөл, төсөвт магадлал хийлгэх нөхцөл үүсдэг. Ингэснээр анх улсын төсөвт суулгасан санхүүжилтын дүн нь бодит биш байсны улмаас магадлал хийх явцад бодит үнэ батлагдахад төсөвт өртгийн зөрүү гарч ирдэг байна.

Жишээ 3. 240 хүүхдийн 49-р цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсөл, төсөв /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг дүүрэг/

Хүснэгт 2.6. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх шалтгаан 4

ТАХ-ны нэр	Огноо	Төсөвт өртөг. сая төгрөг
Улсын төсөв анх суусан огноо, анх батлагдсан төсөвт өртөг	2022	2,800.0
Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан	2022.05.05	2,798.0
Зураг төслийн магадлал <ul style="list-style-type: none"> <li>• Барилга: 4,849.0</li> <li>• ГИШС: 587.0</li> <li>• Тохижилт: 363.0</li> <li>• Тоног төхөөрөмж: 111.0</li> <li>• Зураг төсөл: 32.0</li> </ul>	2022.12.30	5,943.0
<b>Төсөвт өртгийн зөрүү</b>		<b>3,143.0</b>

Жишээ 4. Батлагдсан зураг төсөлтэй улсын төсөвт санхүүжилт суулгаж тендер зарлаж гэрээ байгуулсан ч нэмэлт ажлыг улмаас ажлын тоо хэмжээ өсч дахин магадлал хийлгэх

Тухайн ТАХ нь батлагдсан зураг төсөлтэй, ингээд улсын төсөвт санхүүжилт суулгаж улмаар тендер зарлан гэрээ байгуулсан байдаг. Гэвч гүйцэтгэлийн явцад гүйцэтгэгчийн хүсэлтээр нэмэлт оруулах байдлаар ажлын тоо хэмжээ өссөн ТАХ-үүд байдаг.

Жишээ 4. XII.1.1.54 кодтой, 320 хүүхдийн сургуулийн барилгын нэмэлт ажил /Говь-Алтай аймаг, Дэлгэр сум

Хүснэгт 2.7. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх шалтгаан 5

ТАХ-ны нэр	Огноо	Төсөвт өртөг. сая төгрөг
Зураг төсөл магадлал хийгдсэн	2018.05.01	2,100.0
Улсын төсөв анх суусан огноо, анх батлагдсан төсөвт өртөг	2018	2,100.0
Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан	2018.07.20	1,995.0
Улсын төсөв анх суусан огноо, дахин тусгаж батлагдсан төсөвт өртөг	2019	2,865.0
Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээнд нэмэлт оруулсан	2019.08.15	2,865.0
Зураг төслийн магадлал /Нэмэлт, өөрчлөлт/	2022.08.12	3,408.0
<b>Төсөвт өртгийн зөрүү</b>		<b>543.0</b>

Шалтгаан 5. Захиалагчийн хүсэлтээр зураг төсөл, төсөвт тусгагдаагүй ажлуудад нэмэлтээр магадлал хийлгэх

Тухайн ТАХ нь батлагдсан зураг төсөлтэй, ингээд улсын төсөвт санхүүжилт суулгаж улмаар тендер зарлан гэрээ байгуулсан байдаг. Гэвч гүйцэтгэлийн явцад захиалагчийн хүсэлтээр нэмэлт оруулах байдлаар ажлын тоо хэмжээ өссөн ТАХ-үүд байдаг.

Жишээ 5. “Гадна тохижилтын ажил”-ын өөрчлөлтийн ажлын зураг төсөл /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг/

Хүснэгт 2.7. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх шалтгаан 6

ТАХ-ны нэр	Огноо	Төсөвт өртөг. сая төгрөг
Зураг төсөл магадлал хийгдсэн	2021.12.25	929.0
Захиалагчийн хүсэлтээр зураг төслийн даалгавар өөрчлөгдөж зураг төсөл, төсвийг магадлалаар дахин оруулсан	2022.12.07	1,339.0
Зураг төслийн магадлал /Нэмэлт, өөрчлөлт/	2022.12.07	1,339.0
<b>Төсөвт өртгийн зөрүү</b>		<b>410.0</b>

Шалтгаан 6. Хүчин чадал нэршил ижил боловч барилгын хэмжээ, материалын сонголт, гадна ханын фасадны хийцлэл, байршил өөр учраас зөрүү ихтэй

Энэ шалтгааны улмаас нэршил ижил, ашиглалтын хүчин чадал ижил ТАХ-ны төсөвт өртөг өөр өөрөөр батлагдах нь бий.

Жишээлбэл:

- Барилгын хэмжээ- ижил
- Хүчин чадал-150 хүүхэд ижил
- Байршил- өөр
- Төсөв- их зөрүүтэй

Жишээ 6. 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын 2 ижил ТАХ-ны төсөвт өртөг өөр өөр байгаа байдал

Хүснэгт 2.7. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдөх дараах хэд хэдэн үндсэн Шалтгаан 6

ТӨСӨВТ ӨРТГИЙН ЗАДАРГАА	Архангай аймгийн Батцэнгэл суманд баригдах 150 хүүхдийн цэцэрлэг /Барилга нь 42.0 м х 13.0 м хэмжээтэй, 2 давхар, 1092 м2 талбайтай/	Орхон аймгийн Баян-Өндөр суманд баригдах 150 хүүхдийн цэцэрлэг /Барилга нь 32.0 м х 19.2 м хэмжээтэй, 2 давхар, 1229 м2 талбайтай/	ТӨСӨВТ ӨРТГИЙН ЗӨРҮҮ
Барилга угсралтын ажил	2,283,865,520	2,843,612,088	559,746,568
Гадна тохижилт	187,309,517	679,868,984	492,559,467
Гадна шугам сүлжээний ажил	241,604,567	326,655,877	85,051,310
Зуухны барилга	109,875,516	-	(109,875,516)
Зураг төслийн үнэ	38,000,000	44,952,000	6,952,000
<b>Нийт төсөвт өртөг</b>	<b>2,860,655,120</b>	<b>3,895,088,949</b>	<b>1,034,433,829</b>

Эх сурвалж: Барилгын хөгжлийн төв

### 2.1.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

**Аудитын дүгнэлтээс харахад өмнөх оноос шилжин хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй орхигдуулсан ба төсөл, арга хэмжээний өртгийг нэмэгдүүлэх замаар шинэ арга хэмжээг шилжих нэрээр төлөвлөсөн байна**

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд шинэ ТАХ-ний тоог хязгаарлаж, өмнөх онуудад эхлүүлсэн шилжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлж ашиглалтад оруулах чиглэл баримтлахаар төлөвлөжээ.

Гэтэл хуулийн төслийн дээрх үзэл баримтлал, чиглэлээ баримтлахгүйгээр, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6<sup>10</sup> дахь заалтыг зөрчин өмнөх оноос шилжин хэрэгжих болон хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний нэр дээр 12.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр эхлэх 2 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

**Өмнөх оноос шилжин хэрэгжих зарим төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй орхигдуулсан ба төсөл, арга хэмжээний өртгийг нэмэгдүүлэх замаар шинэ арга хэмжээг шилжих нэрээр төлөвлөсөн байна.**

- ХХААХҮС-ийн багцад 2022 оноос 2023 онд шилжин хэрэгжих Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” /Булган/ ТАХ-ний 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг 6 дахин нэмэгдүүлж Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл аймагт хэрэгжих 10.2 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ ажлыг;
- ХХААХҮС-ийн багцад 2023 оноос шинээр эхлэн хэрэгжих 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/-ыг 2022 оноос шилжих арга хэмжээ нэрээр тусгасан байна.

Өмнөх онуудад эхлүүлсэн зарим төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй, гүйцэтгэгч болон захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалан ажил зогссон байна. Тухайлбал:

- Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9, 10 дугаар хороо/ (2020 он);
- Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/
- Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ (2010 он);
- Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/ (2018 он);
- Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо/ (2012 он);
- Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, 60 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ (2011 он);
- Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Наран баг/ (2019 он);
- Спорт заалны барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/ (2018 он) зэрэг байна.

Төсөвт тусгаагүй, орхигдуулсан ТАХ-ний хугацаандаа хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, гэрээг дүгнэн үргэлжлүүлэн санхүүжүүлэх, эсвэл цуцалж хариуцлага тооцох зэргээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох,

---

<sup>10</sup> 27.6. “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална: 27.6.1. шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ; 27.6.2. их засвар, засвар арчлалтын төсөл, арга хэмжээ; 27.6.3. шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ”

шаардлагатай санхүүжилтийг ирэх онуудын төсөвт тусгах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Эдгээр нь улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй, шаардлага, эрэмбэ дарааллыг баримтлаагүйг харуулж байна.

**Барилга байгууламжийн төсөвт өртөг, нэмэгдэл зардлын тооцоололд тавих хяналт хангалтгүй байна.**

БХТ-ийн магадлалын ажлын дүнг нэгтгэн хүргүүлсэн БХБС-ын судалгаа, албан бичиг, магадлалын дүгнэлтүүдэд тулгуурлан улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 566 төсөл, арга хэмжээнд 297.5 тэрбум төгрөгийн бараа материалын үнийн өсөлтийн зөрүү олгохоор төсөвт тусган баталжээ.

Улсын Их Хурлын 2022 оны 88 дугаар тогтоолын дагуу бараа материалын үнийн өсөлтийн зөрүүг тооцохдоо 2020 онд улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээж авсан дараах 3 төсөл, арга хэмжээнд 0.3 тэрбум төгрөг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Үүнд:

- *Сум дундын эмнэлгийн барилга /Дундговь, Эрдэнэдалай сум/ төсөл, арга хэмжээг улсын комиссын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн БА-01/2020 дүгнэлтээр ашиглалтад оруулсан байхад 2023 оны 02 дугаар сарын 17-нд 0.2 тэрбум төгрөгийн материалын үнийн өсөлтийн зөрүүг тооцож олгохоор нэмэлт гэрээ байгуулсан;*
- *Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 2020 оны 12 дугаар 14-ний өдөр Улсын комисс ажиллаж УҚД-2020/84, УҚД-2020/85 тоот актаар хүлээж авсан байхад материалын үнийн өсөлтийн зөрүүд 0.05 тэрбум төгрөг төлөвлөж санхүүжүүлсэн;*
- *Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14 дүгээр баг/ төсөл, арга хэмжээний 2 барилгыг 2020 онд улсын комисс ажиллан УҚД-2020/46, УҚД-2020/71 тоот актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байхад материалын үнийн өсөлтийн зөрүүд 0.04 тэрбум төгрөг тус тус төлөвлөж санхүүжүүлсэнд албан шаардлага хүргүүлэв.*
- *ЭХС-ын багцын Сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн систем /Хэнтий, Баян-Овоо сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэлтэй*

Энэ нь Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 75 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга байгууламжийн төсөвт өртгийн /барилгын материалын үнэ/ өөрчлөлтийг тооцох түр журам"-ын 2.1<sup>11</sup> дэх заалтад нийцээгүй байна.

Төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан 17 төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээг байгуулахдаа гүйцэтгэгчийн тендерт санал болгосон 0.6 тэрбум төгрөгийн

<sup>11</sup> Энэ журмаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээг байгуулсан бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших үлдэгдэл ажилд материалын үнийн дундаж өсөлтөөр тооцоход хамаарна"

хэмнэлтийг хасаж тооцоогүйд гэрээний үнийн дүнг бууруулах албан шаардлага хүргүүлж, илүү олгосон санхүүжилтийг улсын төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

Дээрх байдлаар нэмэлт санхүүжилтийн гэрээг байгуулахдаа тендерийн хэмнэлтийг хасаж тооцоогүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>12</sup>, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>13</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3<sup>14</sup> дахь заалтад нийцээгүй байна.

Зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажуулсан төсвийн дүнгээс илүү тусгасан, хэсэгчилсэн болон нэгдсэн магадлалын дүнг давхардуулан тооцож нэмэлт гэрээ байгуулан санхүүжүүлсэн 3.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- ЭХС-ын багцын Сумын төвийн байгууллагуудын дулаан хангамжийн систем /Хэнтий, Баян-Овоо сум/ төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэлтэй холбоотой магадлалаар баталгаажсан зураггүй, анхны гэрээний хүрээнд төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдэж, улсын комисс хүлээн авсан байхад төсөвт өртгийг 0.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны төсөвт тусгасан;
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Дадал сум/ ТАХ-ний төсөвт өртгийг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны магадлалын ерөнхий дүгнэлтээр 2.2 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан байхад ажил гүйцэтгэх гэрээнд 2023 оны 05 дугаар сарын 17-нд нэмэлт өөрчлөлт оруулахдаа дээрх дүнгээс 0.2 тэрбум төгрөгөөр илүү дүнгээр гэрээ байгуулж, эмнэлгийн барилгын засварын ажлыг гүйцэтгүүлсэн;
- БШУС-ын багцын Сургуулийн барилга, 320 суудал /Хэнтий, Жаргалтхаан сум/ ТАХ-ний барилгын материалын үнийн өсөлтийн зөрүүг баталгаажуулсан БХТ-ийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 88-086/2022 дугаартай магадлалын дүгнэлтийн үнийн дүн 1.1 тэрбум төгрөгийг 2022 оны 08 дугаар сарын 15-ны 1448/2022 дугаартай магадлалаар баталгаажуулсан нийт төсөвт өртгийн 7.0 тэрбум төгрөгийн дүнтэй давхардуулан тооцож илүү дүнгээр гэрээ байгуулсан;
- БШУС-ын багцын Дотуур байрны барилга, 100 ор /Хэнтий, Дэлгэрхаан сум/ ТАХ-ний барилгын материалын үнийн өсөлтийн болон нийт төсөвт өртгийн магадлалын дүгнэлтийг давхардуулан 1.6 тэрбум төгрөгийг илүү тооцож, гэрээ байгуулсан зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ.

---

<sup>12</sup> 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"

<sup>13</sup> 6.1. "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална";

<sup>14</sup> 13.1.3. "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх"

Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5<sup>15</sup>, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 6 дугаар зүйлийн 6.17<sup>16</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.1.2<sup>17</sup>, Төсвийн тухай хуулийн 6.4.1<sup>18</sup> дэх заалттай тус тус нийцээгүй байна.

Дээрх байдлаар төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний гэрээнд өөрчлөлт оруулахдаа ХАА-нд анх санал болгосон тендерийн хэмнэлтийг хасаж тооцохгүй байх, магадлалын дүгнэлтийг давхардуулан тооцож төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж байгаа зэрэг нь төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчимд нийцэхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тэргүүлэх ач холбогдол, хүрэх үр дүн, шилжих болон шинээр эхлэхээр эрэмбэлж, төлөвлөлтийн шаардлага хангасан тохиолдолд төсөвт тусгах, хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан санхүүжилтийг төлөвлөх зарчмуудыг хэрэгжүүлэхгүй байгаа нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

## **2.2. 2024-2025 оны улсын төсвийн тухай хууль, 2026 оны Улсын төсвийн тухай хуулийн төсөл дэх УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтөд хийсэн дүгнэлт**

Бид УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-ны анхны төсөвт өртөг өөрчлөгдсөн байдлыг сүүлийн 3 жилийн төсвийн тухай хуулиас түүвэрлэн авч боловсруулалт хийж үзлээ. Ингэхдээ, 2024-2025 оны улсын төсвийн тухай хууль, 2026 оны Улсын төсвийн тухай хуулийн төсөл дэх УТХО-аар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтөд дүгнэлт хийсэн болго.

Тухайн жилүүдийн төсвийн тухай хуулийн хавсралт 2-оор бэлтгэсэн УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-г нэгтгэн 3 жилийн хугацаан дахь дахцсан буюу он дамжсан ТАХ-ны давхардлыг арилгаж дараах нийлбэр дүнтэй байна. Давхардал гэдэг нь он төсөвт өртөг нь шинээр тогтоогдож, он дамжин санхүүжихээр ижил нэртэй, ижил кодтой ТАХ-ыг нэг болгон сүүлийн оноор нь авсан болно. Үүнд:

*Хүснэгт 2.8. Сүүлийн 3 жилийн байдлаар төсөв өртөг нь өөрчлөгдсөн ТАХ-ны нийт дүн*

	Төсөвт өртгийн өөрчлөлтийн нийт дүн. сая.төгрөг
--	---

<sup>15</sup> 25.5. "Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ";

<sup>16</sup> 6.17. "Магадлал хийж баталгаажсан зураг төслийг болон барилга байгууламжийн нэг маягийн зургийг давтан хэрэглэх тохиолдолд ажлын зургийн өөрчлөлт орсон хэсэгт магадлал хийлгэнэ";

<sup>17</sup> 41.1.2. "Энэ хуулийн 40.4, 40.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглоно";

<sup>18</sup> "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"

Анхны төсөвт өртөг нь өөрчлөгдсөн ТАХ-ны он	ТАХ-ний тоо	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Зөрүү
2024 он	356	2,077,862	3,361,957	1,284,095
2025 он	71	491,076	745,497	254,421
2026 он	95	524,850	888,926	364,076
Нийт 3 жилээр	522	3,093,788	4,996,380	1,902,591

Хүснэгтээс харахад, УТХО-аар санхүүжүүлсэн (2024, 2025 онуудын төсвийн тухай хууль, 2026 оны төсвийн төсөл) төсөвт өртөг нь өөрчлөгдсөн ТАХ-ны хувьд сүүлийн 3 жилээр давхардлыг нь арилгаж тооцоход нийтдээ 522 ТАХ байгаа бөгөөд эдгээр ТАХ-ний анхны төсөвт өртөг нь 3,093,788 сая төгрөг, тайлант оны төсөв (төсөвт өртөг нь нэмэгдэж орж ирсэн) 4,996,380 сая төгрөг байгаа ба төсөвт өртгийн нэмэгдсэн зөрүү нь 1,902,591 сая төгрөг буюу 1.9 их наяд төгрөг болж байна.

*Хүснэгт 2.9. Төсөвт өртөг нь өөрчлөгдсөн ТАХ-г ТЕЗ-аар нь харьцуулсан байдал*

он	2024		2025		2026		Нийт дүн	
	ТАХ-ний тоо	Зөрүү	ТАХ-ний тоо	Зөрүү	ТАХ-ний тоо	Зөрүү	ТАХ-ний тоо	Зөрүү
Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Сайд	1	178					1	178
Батлан Хамгаалахын Сайд	3	941	1	4,782			4	5,723
Боловсролын Сайд	160	302,449	35	83,531	57	135,135	252	521,115
Гэр Бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд	10	29,246	1	286	3	7,818	14	37,350
Зам, Тээврийн Сайд	22	237,143	6	41,962	2	8,513	30	287,619
Монгол Улсын Сайд, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын Дарга	10	12,862	1	1,896			11	14,758
Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд Бөгөөд Эдийн Засаг, Хөгжлийн Сайд	1	60,492	1	1,279			2	61,771

Монгол Улсын Шадар Сайд	1	8,061					1	8,061
Сангийн Сайд	3	92,702					3	92,702
Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын Сайд	45	201,994	9	30,382	18	90,342	72	322,718
Улсын Ерөнхий Прокурор	2	3,507			1	34,552	3	38,059
Хот Байгуулалт, Барилга, Орон Сууцжуулалтын Сайд	27	80,272	9	53,152	5	46,083	41	179,506
Хууль Зүй, Дотоод Хэргийн Сайд	9	10,950			1	2,005	10	12,955
Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайд	16	26,305	3	20,396	1	1,721	20	48,422
Цахим Хөгжил, Инновац, Харилцаа Холбооны Сайд			1	4,426			1	4,426
Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Дарга	1	60,955					1	60,955
Эрүүл Мэндийн Сайд	39	101,296	3	11,177	5	21,448	47	133,921
Эрчим Хүчний Сайд	6	54,741	1	1,152	2	16,460	9	72,352
<b>Нийт</b>	<b>356</b>	<b>1,284,095</b>	<b>71</b>	<b>254,421</b>	<b>95</b>	<b>364,076</b>	<b>522</b>	<b>1,902,591</b>

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 3 жилийн төсвийн тухай хуульд тусгагдсны нийлбэрээр Боловсролын сайдын багцад буй ТАХ-ний төсөвт өртөг өөрчлөгдсөн байдал нийт 252 ТАХ байгаа бөгөөд төсөвт өртгийн өөрчлөлтийн нийлбэр нь 521.1 тэрбум төгрөг байгаа нь хамгийн их байна.

Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын Сайдын багцад 72 ТАХ-ний төсөвт өртөг 322.7 тэрбумаар, Эрүүл Мэндийн Сайдын багцад 47 ТАХ-ний төсөвт өртөг 133.9 тэрбумаар, Хот Байгуулалт, Барилга, Орон Сууцжуулалтын Сайдын багцад 41 ТАХ-ний төсөвт өртөг 179.5 тэрбумаар, Зам, Тээврийн Сайдын багцад 30 ТАХ-ний төсөв өртөг 287.6 тэрбум төгрөгөөр гэх мэтээр анхны төсөвт өртөг нь өөрчлөгдсөн ТАХ их хэмжээгээр тусгагджээ.

*Хүснэгт 2.10. ТАХ-ны анхын болон нэмэгдсэн төсөвт өртөг түүний зөрүү, батлагдсан он, ТАХ-ны тоогоор*

Төсвийн он	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Төслийн тоо	Зөрүү /Сая.Төгрөг/	Зөрүү /Хувь/
2024	4,082,097.39	11,579,680.28	1,319	7,497,582.89	183.67%
2025	6,502,096.15	12,134,006.10	639	5,631,909.95	86.62%
2026	6,205,277.90	9,631,879.80	579	3,426,601.90	55.22%
Нийн дүн	16,789,471.44	33,345,566.18	2,537	16,556,094.74	

Хүснэгтээс харахад, сүүлийн 3 жилийн байдлаар УТХО-аар батлагдсан нийт ТАХ-ны тоо нь 2,537 байна. Үүнээс 2024 онд 1319, 2025 онд 639, 2026 оны төсвийн төсөлд 579 ТАХ орж иржээ.

2024 оны УТХО-аар санхүүжих нийт 1319 ТАХ-ын анхны төсөв өртөг нь 4.0 их наяд төгрөг байсан бол 2024 оны байдлаар зарим ТАХ-ний төсөв өртөг нэмэгдсэнээр 11.6 их наяд төгрөг болж 7.5 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин 2025 оны хувьд нийт 6.5 их наяд төгрөгийн анх батлагдсан төсөвт өртөгтэй 639 ТАХ-ний төсөвт өртөг 12.1 их наяд болж 5.6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн, 2026 оны төсвийн төсөлд нийт 6.2 их наядын анх батлагдсан төсөвт өртөгтэй 579 ТАХ хэмжээ тусгагдаж орж ирэхдээ 9.6 их наядын төсөвт өртөгтэй болж 3.4 их наяд төгрөгөөр төсөвт өртөг нь нэмэгдсэн байдалтай байна. Энэ дүнгүүд нь давхардсан дүнгээр тул бид үүнийг сүүлийн 3 жилийн хугацаанд давхардлыг арилгаж дараах байдлаар ангилж үзлээ.

*Хүснэгт 2.11. ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдсөн байдал (давхардлыг арилгасан байдлаар)*

Төсвийн он	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Төслийн тоо	Зөрүү /Сая.Төгрөг/	Зөрүү /Хувь/
2024	2,077,862.27	3,361,956.86	356.00	1,284,094.59	0.62
2025	491,075.92	745,496.60	71.00	254,420.68	0.52
2026	524,850.20	888,926.10	95.00	364,075.90	0.69
Нийт дүн	3,093,788.39	4,996,379.56	522.00	1,902,591.17	

Хүснэгтээс харахад, сүүлийн 3 жилийн УТХО-аар санхүүжих ТАХ-ний тоо өмнө 2537 байсан бол төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ-г давхардлыг нь арилгаж түүвэрлэхэд нийт 3 жилийн төсөвт 522 ТАХ байгаа нь хүснэгтээс харагдана.

2024 оны байдлаар, 356 ТАХ-ний анх батлагдсан төсөвт өртөг дунджаар 62%-аар нэмэгдсэн, 2025 оны байдлаар 71 ТАХ-ний анх батлагдсан төсөвт өртөг дунджаар 52%-аар нэмэгдсэн, 2026 оны төсвийн төсөлд 95 ТАХ-ний анх батлагдсан төсөвт өртөг дунджаар 69%-аар нэмэгдсэн байдалтай байна. Сүүлийн 3 жилд нийт 522 ТАХ-ний төсөв өртөг 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь 3 жилийн төсөвт үзүүлсэн бодит дарамт гэж тооцож болно.

2024 оны байдлаар анх 2010 онд төсөвт өртөг нь батлагдсан ТАХ-г УТХО-аар нэмж санхүүжүүлэх 2027 онд дуусгахаар оруулж ирсэн байна. Энэ байдлаар 2-14

жилийн хугацаанд үргэлжилж байгаа нийт 356 төсөл арга хэмжээ төсөвт өртөг өөрчлөгдсөнийг доорх хүснэгтээс харж болно.

*Хүснэгт 2.12. ТАХ-ны төсөв өртөг өөрчлөгдсөн байдал (анх батлагдсанаас хойш үргэлжилж буй жилээр)*

Төсвийн он ба үргэлжилж буй жилийн тоо	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Төслийн тоо	Зөрүү /Сая.Төгрөг/	Зөрүү /Хувь/
<b>2024</b>	<b>2,077,862.27</b>	<b>3,361,956.86</b>	<b>356</b>	<b>1,284,094.59</b>	<b>61.80%</b>
2	262,401.17	398,389.23	86	135,988.06	51.82%
3	704,245.10	1,023,213.42	100	318,968.32	45.29%
4	464,381.10	736,240.43	78	271,859.33	58.54%
5	190,459.90	331,515.73	52	141,055.83	74.06%
6	337,359.40	498,100.43	25	160,741.03	47.65%
7	40,592.00	126,000.45	3	85,408.45	210.41%
10	25,528.00	40,125.39	4	14,597.39	57.18%
11	7,162.00	27,798.04	2	20,636.04	288.13%
12	12,000.00	25,671.35	1	13,671.35	113.93%
13	29,041.00	131,725.69	3	102,684.69	353.59%
14	4,692.60	23,176.70	2	18,484.10	393.90%
<b>2025</b>	<b>491,075.92</b>	<b>745,496.60</b>	<b>71</b>	<b>254,420.68</b>	<b>51.81%</b>
1	60,576.32	69,784.40	2	9,208.08	15.20%
3	178,683.90	280,383.80	35	101,699.90	56.92%
4	133,627.60	235,515.00	14	101,887.40	76.25%
5	25,208.10	43,735.10	9	18,527.00	73.50%
6	78,580.00	90,117.20	5	11,537.20	14.68%
7	5,400.00	14,222.50	4	8,822.50	163.38%
12	5,000.00	6,459.80	1	1,459.80	29.20%
13	4,000.00	5,278.80	1	1,278.80	31.97%
<b>2026</b>	<b>524,850.20</b>	<b>888,926.10</b>	<b>95</b>	<b>364,075.90</b>	<b>69.37%</b>
2	57,953.70	73,088.10	20	15,134.40	26.11%
3	147,404.40	189,608.70	14	42,204.30	28.63%
4	107,372.00	151,064.60	13	43,692.60	40.69%
5	81,891.10	145,723.90	14	63,832.80	77.95%
6	50,400.00	96,400.80	13	46,000.80	91.27%
7	18,127.00	40,556.30	10	22,429.30	123.73%
8	16,362.70	28,769.20	5	12,406.50	75.82%
12	15,640.00	39,655.90	1	24,015.90	153.55%
14	20,338.00	76,335.60	3	55,997.60	275.33%

16	2,561.30	14,732.90	1	12,171.60	475.21%
17	6,800.00	32,990.10	1	26,190.10	385.15%
<b>Нийт</b>	<b>3,093,788.39</b>	<b>4,996,379.56</b>	<b>522</b>	<b>1,902,591.17</b>	<b>61%</b>

Хүснэгт 2.13. Анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдсөн ТАХ-ний тоо (ТЕЗ-аар)

ТЕЗ ба төсөвт өртөг нь өөрчлөгдсөн ТАХ-ний тоо	2010	2011	2012	2013	2014	2015	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	Нийт
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА													1	2	2	5
АЖ УИЛДВЭР ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД														1		1
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧӨЛГӨЛТИЙН САЙД								1			1		26	6	8	42
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД											3		9	2	7	21
БОЛОВСРОЛЫН САЙД			1	1	1	2	27	54	73	68	173		401	3	32	836
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД													2	4	1	7
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД					2			1	2	10	8		54	3	1	81
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД							1	14	9	8	35		191	36	9	303
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР													1	1	1	3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД													1	1	2	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ														2	1	3
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА													2	2	1	5
МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА												3	2	3		8
МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРТЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА													2	3		5
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА								2	4	5	5		51	2	3	72



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД										2	9	7	7	33		127	6	13	204
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД										3	3	1	1	21	3	69	21	6	125
Нийт	3	7	6	7	8	2	36	113	136	149	412	6	1357	146	149	2537			

Зарим ТАХ-ний төсөвт өртөг дараалан нэмэгдэж, батлагдсан төсвөөсөө ч давсан байдалтай харагдаж байна.

Төсвийн он	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадла, байршил	Төсвийн захиран зарцуулах нэрж	Төслийн код	Эхлэх Хугацаа	Дуусах Хугацаа	Хэрэгжүүлсэн хугацаа	Анхны Төсөвт өртөг	Сүүлийн Төсөвт өртөг	Тайлант ОНЫ Төсөв	Тайлант оны Санхүүжүүлэх дүн
2019	XII.1.1.22	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД		2019	2020	1	48,000.00			5,000.00
2020	XIII.1.1.13	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД		2019	2021	2	48,000.00			16,000.00
2021	XV.1.1.9	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД		2019	2022	3	48,000.00			11,000.00
2022	XV.1.1.10	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД		2019	2023	4	48,000.00			6,491.60
2023	XII.1.1.19	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу	ЗАМ, ТЭЭВРИЙН		2019	2023	4	48,000.00		47,140.30	8,515.60

		Хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ХӨРЖЛИЙН САИД																
2024	XV.1.1.4	Багануур- Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН САИД	УТ2002800867	2019	2025	6	48,000.00	52,102.00	4,000.08									
2025	XVI.1.1.98	Багануур- Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН САИД	УТ2002800867	2019	2025	6	48,000.00	52,101.99	52,102.00	19,901.60								
2026		Багануур- Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	ЗАМ, ТЭЭВРИЙН САИД	УТ2002800867	2019	2026	7	48,000.00	52,102.00	52,102.00	4,000.10								
																			<b>74,908.98</b>

Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/ нь анх 2019 онд УТХО-аар санхүүжүүлэхээр төсөвт 48.0 тэрбум төгрөг тусгагдсан байна. Гэвч 8 жилийн хугацаанд жил бүр төсөв тавигдсаар ирсэн байх бөгөөд 2024 онд төсөвт өртөг нь 52.1 болж 19.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол 2026 оны төсөв хүртэл 8 жилийн хугацаанд жил бүрийн улсын төсөвт тавигдсан санхүүжилтын дүн 74.9 тэрбум төгрөг болсон харагдаж байна. Өнгөрсөн 8 жилийн төсвийн төслөөс харахад жил бүр санхүүжилт тавигдсан байгаа харагдаж байгаа ч тухайн жилийн гүйцэтгэлээр хэдэн төгрөгийн санхүүжилт хийгдсэнийг нягтлах шаардлагатай.

## Гурав. ҮНЭЛГЭЭ

### 3.1. Хууль тогтоомж хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцэж байгаа эсэх

Монгол Улсын төсвийн тухайн жилийн төсөлд УИХ-д хэлэлцэн батлуулахаар оруулж ирж байгаа УТХО-аар санхүүжүүлэх ТАХ-нд төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-г заасан "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана." гэснийг зөрчиж, нэг маягийн зураг төсвөөр эсвэл ТЭЗҮ, зураг төсөвгүй ТАХ-г төсөвт суулгаж батлуулж байгаа зөрчил ихээр байгааг цаашид шийдвэрлэх шаардлагатай.

Гэтэл үүнээс улбаалж ТАХ-ний төсөвт өртөг өөрчлөгдөх байдал жил бүрийн төсвийн төсөлд ихээр орж байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтад багагүй дүн үзүүлж байна.

*Хүснэгт 2.14. УТХО-аар санхүүжсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн тоо, нэмэгдсэн зөрүү (сая төгрөгөөр)*

Улсын төсөв батлагдсан он	ТАХ-ний тоо	Анхны төсөвт өртөг нь нэмэгдэж өөрчлөгдсөн зөрүү. Сая төгрөгөөр
2024 он	356	1,284,095
2025 он	71	254,421
2026 он	95	364,076

### 3.2. Тоон болон чанарын үнэлгээ

Төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ-г ТЕЗ-аар нь гаргаж үнэлж үзэхэд төсөвт өртөг нэмэгдсэн байдал харилцан адилгүй байгаа хэдий ч Боловсролын сайдын багцад жил бүр өндөр дүнгээр орж ирж байна.

*Хүснэгт 2.15. ТЕЗ-ийн УТХО-аар санхүүжүүлж буй ТАХ-ны төсөвт өртгийн нэмэгдэл /сая төгрөгөөр/*

Төсвийн Ерөнхийлөн Захирагч	2024	2025	2026	Дүн
	Зөрүү	Зөрүү	Зөрүү	Зөрүү
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	177.83	-	-	177.83
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	940.56	4,782.38	-	5,722.94
БОЛОВСРОЛЫН САЙД	302,449.03	83,530.90	135,135.40	521,115.33
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	29,246.47	285.80	7,817.60	37,349.87

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	237,143.47	41,962.30	8,512.90	287,618.67
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	12,862.14	1,895.90	-	14,758.04
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	60,491.72	1,278.80	-	61,770.52
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	8,061.20	-	-	8,061.20
САНГИЙН САЙД	92,702.30	-	-	92,702.30
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	201,993.98	30,382.20	90,342.00	322,718.18
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	3,506.60	-	34,552.40	38,059.00
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	80,271.72	53,152.00	46,082.50	179,506.22
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	10,950.45	-	2,004.60	12,955.05
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	26,305.21	20,396.10	1,721.00	48,422.31
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	-	4,425.70	-	4,425.70
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	60,954.90	-	-	60,954.90
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	101,295.74	11,176.90	21,448.00	133,920.64
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	54,741.27	1,151.70	16,459.50	72,352.47
<b>Нийт</b>	<b>1,284,094.59</b>	<b>254,420.68</b>	<b>364,075.90</b>	<b>1,902,591.17</b>

Хүснэгт 2.16. ТЕЗ-ийн УТХО-ын ТАХ-ний төсөв өртөг өөрчлөгдсөн байдлыг ТАХ үргэлжилсэн хугацаагаар авч үзвэл

ОН	Нийт дүн	Нийт дүн	Нийт дүн	Нийт дүн
ҮЗҮҮЛЭЛТ	Төслийн тоо	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Зөрүү
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	1	450	628	178
2	1	450	628	178

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	4	45,600	51,323	5,723
2	3	5,024	5,964	941
1	1	40,576	45,359	4,782
БОЛОВСРОЛЫН САЙД	252	872,483	1,393,598	521,115
14	1	3,238	5,437	2,199
11	1	2,162	10,558	8,396
10	2	14,150	24,639	10,489
8	3	9,363	14,000	4,637
7	10	22,724	42,850	20,126
6	26	94,566	176,793	82,227
5	37	110,959	198,558	87,600
4	54	164,570	272,104	107,534
3	70	303,653	450,622	146,969
2	48	147,099	198,036	50,937
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	14	40,959	78,309	37,350
11	1	5,000	17,240	12,240
7	1	1,200	4,175	2,975
4	2	3,180	9,929	6,749
3	8	26,434	39,617	13,183
2	2	5,145	7,347	2,202
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	30	773,883	1,061,502	287,619
8	1	2,000	8,048	6,048

6	2	117,000	123,173	6,173
5	6	58,100	69,406	11,306
4	12	316,952	505,473	188,521
3	8	279,531	354,826	75,295
2	1	300	577	277
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	11	31,885	46,643	14,758
5	2	2,354	3,102	748
4	5	24,727	29,628	4,901
3	1	300	502	202
2	3	4,504	13,411	8,907
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	2	98,000	159,771	61,771
13	1	4,000	5,279	1,279
6	1	94,000	154,492	60,492
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	1	4,400	12,461	8,061
3	1	4,400	12,461	8,061
САНГИЙН САЙД	3	42,095	134,798	92,702
7	1	32,195	114,144	81,949
2	2	9,900	20,654	10,754
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	72	359,673	682,391	322,718
17	1	6,800	32,990	26,190
16	1	2,561	14,733	12,172

14	2	8,985	41,372	32,386
13	2	14,041	55,771	41,730
12	1	12,000	25,671	13,671
10	1	6,378	10,045	3,667
7	3	4,000	6,734	2,734
6	8	113,340	160,413	47,073
5	19	61,549	120,545	58,996
4	12	47,751	86,774	39,023
3	16	65,274	104,655	39,381
2	6	16,994	22,688	5,695
<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>	<b>3</b>	<b>22,485</b>	<b>60,544</b>	<b>38,059</b>
14	1	10,000	44,552	34,552
4	1	4,539	5,733	1,194
3	1	7,947	10,259	2,313
<b>ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД</b>	<b>41</b>	<b>328,998</b>	<b>508,504</b>	<b>179,506</b>
14	1	2,807	8,151	5,344
12	2	20,640	46,116	25,476
10	1	5,000	5,441	441
6	1	250	412	162
5	3	17,540	34,338	16,798
4	8	44,828	82,348	37,520
3	17	223,563	308,383	84,820

2	8	14,370	23,315	8,945
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	10	35,226	48,181	12,955
4	2	22,725	25,730	3,005
3	2	6,300	12,747	6,447
2	6	6,200	9,704	3,504
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	20	82,643	131,066	48,422
8	1	5,000	6,721	1,721
6	1	2,200	2,408	208
4	4	17,480	25,241	7,761
3	9	52,913	90,058	37,145
2	5	5,050	6,637	1,587
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	1	20,000	24,426	4,426
1	1	20,000	24,426	4,426
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1	15,000	75,955	60,955
13	1	15,000	75,955	60,955
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	47	191,303	325,223	133,921
7	2	4,000	12,876	8,876
6	3	23,800	40,339	16,539
5	6	27,525	52,826	25,300
4	4	6,629	10,185	3,556
3	12	35,604	58,570	22,965
2	20	93,744	150,428	56,684

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	9	128,707	201,059	72,352
6	1	21,184	26,588	5,405
5	2	19,533	42,201	22,668
4	1	52,000	69,676	17,676
3	4	24,415	50,505	26,090
2	1	11,576	12,089	514
Нийт	522	3,093,788	4,996,380	1,902,591

## **Дөрөв. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

УТХО-аар санхүүжүүлсэн ч гүйцэтгэж дуусгалгүй зогссон, дараа жилүүдийн төсвийг улсын төсөвт тусгалгүй гацаасан, анх батлагдсан төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ-ний талаар судалж, Сангийн яам, Барилгын хөгжлийн төвөөс холбогдох мэдээлэл авч харьцуулан, улмаар АЕГ-ын гүйцэтгэлийн аудитын дүгнэлттэй тулган үзэж дараах санал дүгнэлтийг гаргаж байна.

УТХО-аар санхүүжүүлсэн төслүүдэд үүсч буй асуудлууд:

1. 16 жилийн өмнө УТХО-аар санхүүжүүлэхээр эхэлсэн төсөл одоог хүртэл дуусаагүйн улмаас төсөвт өртгийг нь нэмэгдүүлж улсын төсөвт тусгахаар оруулж ирж байгаа нь улсын төсөв дэх хөрөнгө оруулалтын талд асуудал байгааг илтгэж байна.
2. УТХО-аар санхүүжүүлэхээр төсөвт тусгасан хэдий ч он дамнасан санхүүжилтийг нь дараа жилийн улсын төсөвт тусгаагүйгээс гүйцэтгэл саатаж олон жилээр гацсан, улмаар хожим төсөвт тусгахаар оруулж ирэхэд нь инфляцын нөлөөгөөр төсөвт өртөг нь олон дахин нэмэгдсэн ТАХ олон байна.
3. Зураг төсөвгүй ТАХ-г улсын төсөвт тусгасны улмаас төсвийн тухайн жилдээ гүйцэтгэл хийгдэхгүй өнжих, улмаар төсөвт өртөг улсын төсөвт сууснаас өөрөөр магадлал хийгдэж нэмэгдэх байдалтай төслүүд олон байна.
4. Төсөвт өртгийг нь таамгаар тусгаснаас хамаарч дараа нь зураг төсвийг нь баталгаажуулахад бодит байдал дээр төсөвт өртөг нь нэмэгдсэн, хөрөнгө дутсаны улмаас зогссон төслүүд байна.
5. Нэг маягийн зураг, жишиг төсөв ашиглаж улсын төсөвт тусгасан ТАХ-г тухайн байршилд барихаар барилгын зургийн холболт, тохируулга хийх явцад төсөвт өртөг өөрчлөгдөн нэмэгдэх байдалтай төслүүд байна.
6. Гүйцэтгэгч компанийн чадавх, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалтгүй байдлаас уг барилга, байгууламжийн төсөл баригдахгүй зогссон байдалтай ТАХ өнөөдрийг хүртэл гацсаар байна.
7. ТАХ-ний төлөвлөлт, бүртгэл, барилгын ажлын гүйцэтгэлийн төлөвлөлт, бэлтгэл ажил зэрэг нь хангалтгүйн улмаас төсөл хугацаандаа хэрэгжиж ашиглалтад ордоггүй тохиолдлууд их байна.
8. Худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулдаггүй эсвэл захиалагч тал гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн явцад тухай бүр хяналт тавьдаггүйн улмаас чанарын шаардлага хангахгүй зогссон тохиолдлууд байна.
9. Барилга угсралтын ажил болон захиалагч, гүйцэтгэгч компаниудын явцын хяналт дотоод зохион байгуулалт хангалтгүйн улмаас улсын комисс хүлээж авахад зөрчил, доголдол илэрч, акт тавихад түүнийгээ засаж хүлээлгэн өгч чадаагүйн улмаас төсөл зогссон байдлууд аудитын дүгнэлтээс харагдаж байна.
10. Барилга, байгууламжийн төсөлд тавигддаг норм стандартыг хангадаггүйн улмаас мөн улсын комисст хүлээлгэн өгөх боломжгүй зогссон ТАХ-ний талаар аудитын дүгнэлтээс харж болно.
13. УТХО-аар санхүүжүүлэхээр тусгасан ТАХ нь газар чөлөөлөлтийг шийдвэрлээгүйн улмаас барилгын ажил эхлэхгүй саатсан тохиолдлууд байна.

14. УТХО-аар санхүүжүүлэхээр төсөвт тусгаж, тендер зарлаж гэрээ байгуулсан хэдий ч явцын дунд барилгын ажил гүйцэтгэх гэрээг цуцалсны улмаас зогссон ТАХ байна.
15. Үлдэгдэл ажлын тоо хэмжээг үндэслэн шинэчилсэн төсөв гаргуулдаг зэрэг шалтгааныг Аудитын тайлан болон СЯ болон БХТ-өөс ирүүлсэн мэдээлэлд дурдагджээ.

Мөн түүнээс гадна, Монгол Улсын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах (төсвийн тодотгол) үеэр болон Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх үед чуулганы хуралдаанд хийсэн Сангийн сайдын мэдээллээс харахад УИХ-ын гишүүд төсөв хэлэлцэх үедээ зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй ТАХ-ыг улсын төсөвт тусгадаг асуудал нь цаашлаад ТАХ-ны төсөвт өртөг нэмэгдэх үндэс болдог тухай мэдээлсэн.

Үүнийг судлаж үзэхэд:

- 2024 онд 639 ТАХ-г УТХО-аар хэрэгжүүлэхээр тусгасны 449 ТАХ-ний төсөвт өртөг 1,616,832.0 сая төгрөгөөр нэмэгдсэн,
- 2025 онд 1319 ТАХ-г УТХО-аар хэрэгжүүлэхээр тусгасны 142 ТАХ-ний төсөвт өртөг 971,347.0 сая төгрөгөөр нэмэгдсэн,
- 2026 онд 579 ТАХ-г УТХО-аар хэрэгжүүлэхээр тусгасны 136 ТАХ-ний төсөвт өртөг 805,024.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байдалтай байна. Дээр дурдсанаар 2024-2026 оны улсын төсөвт УТХО-аар санхүүжүүлэхээр 3 жилийг дамнан орж ирсэн ТАХ-ний давхцлыг арилгаж, төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ-ний нийт дүнг тооцож үзэхэд 2010 оноос хойших 522 ТАХ-ний төсөвт өртөг нийтдээ 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байдалтай байна.

Хүснэгт. Төсөв өртөг нь нэмэгдсэн ТАХ-ний тоо, нэмэгдсэн дүн (оноор)

Улсын төсөв батлагдсан он	ТАХ-ний тоо	Анхны төсөвт өртөг нь нэмэгдэж өөрчлөгдсөн зөрүү. Сая төгрөгөөр
2024 он	356	1,284,095
2025 он	71	254,421
2026 он	95	364,076
<b>Нийт</b>	<b>522</b>	<b>1,902,591</b>

Засгийн газраас оруулж ирсэн төсвийн төсөл дэх УТХО-аар санхүүжүүлэх ТАХ болон УИХ-аар хэлэлцэх явцад УИХ-ын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар ТЭЗҮ-гүй, зураг төсөвгүй төсөл тусгагддаг нь Төсвийн тухай хуулийн холбогдох хэсгийг зөрчиж байгаа болно. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан байдаг.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29<sup>1.4</sup>-т заасны дагуу Төсвийн хөрөнгө

оруулалтын удирдлагын цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр хэрэгжүүлэхээр заасан хэдий ч төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явцад энэхүү цахим систем дэх төсвийн мэдээллийг харах боломжгүйгээс хамаарч УИХ-ын гишүүд ТАХ-г оруулах зарчмын зөрүүтэй санал гаргахдаа ТЭЗҮ, зураг төсөвгүй төслийг хөндлөнгөөс оруулах байдал ихэссэн байна. Гагцхүү энэ цахим журамд буй, үнэлэгдэж, өндрөөр эрэмбэлэгдсэн төслүүдээс орлуулах боломжтойгоор зохицуулах шаардлагатай нь харагдаж байна.

Иймд судалгааны дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хүрээнд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Хавсралт 1. МУ-ын 2024 оны төсвийн тухай хуульд УТХО-аар санхүүжүүлсэн ТАХ-ны төсөвт өртөг өөрчлөгдсөн байдал (Төсөвт өртөг нэмэгдсэн хувь ихээс бага руу дарааллаар)

Төсөв-ийн он	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Шинэ / Шилжих	Төслийн код	Эхлэх Хугацаа	Дуусах Хугацаа	Төслийн хугацаа	Анхны Төсөвт өртөг	Тайлант оны төсөв	Зөрүү	хувь
2024	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	Шилжих	УТ2101001144	2022	2024	2	500.00	6,512.50	6,012.50	1203%
2024	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/	Шилжих	УТ2003100011	2010	2024	14	1,885.20	15,025.70	13,140.50	697%
2024	Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/	Шилжих	УТ2003400767	2011	2024	13	3,000.00	19,410.40	16,410.40	547%
2024	Сумын төвийн цэвэр усны шугам /Өвөрхангай, Төгрөг сум/	Шилжих	УТ2102900329	2021	2024	3	450.00	2,691.97	2,241.97	498%
2024	Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	Шилжих	УТ2003100016	2019	2024	5	2,000.00	10,892.66	8,892.66	445%
2024	Хуучин орон сууцны дахин төлөвлөлт, дэд бүтэц, хотын инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр сум/	Шилжих	УТ2102900518	2022	2024	2	1,000.00	5,200.00	4,200.00	420%
2024	Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Шилжих	УТ1300500001	2013	2026	13	15,000.00	75,954.90	60,954.90	406%
2024	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/	Шилжих	УТ2001500173	2013	2024	11	2,162.00	10,557.74	8,395.74	388%
2024	Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанхад баг/	Шилжих	УТ2102000115	2021	2024	3	160.00	770.39	610.39	381%
2024	Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн цахилгаан хангамж /Ховд, Дарви сум/	Шилжих	УТ2103001135	2022	2025	3	5,515.00	25,669.70	20,154.70	365%
2024	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/	Шилжих	УТ2103100227	2019	2024	5	250.00	952.04	702.04	281%

2024	Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/	Шилжих	УТ2001100127	2019	2026	7	32,195.20	114,143.90	81,948.70	255%
2024	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	Шилжих	УТ2003900019	2021	2025	4	1,930.00	6,803.90	4,873.90	253%
2024	Усан спорт цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Найрамдал зуслан/	Шилжих	УТ2003900155	2014	2025	11	5,000.00	17,240.30	12,240.30	245%
2024	Багийн төвийн барилга /Ховд, Буянт сум, Наранхайрхан баг/	Шилжих	УТ2001000049	2020	2024	4	250.00	857.02	607.02	243%
2024	Сургуулийн спорт заалны барилга /Говь-Алтай, Дарви сум/	Шилжих	УТ2101500243	2022	2024	2	500.00	1,711.10	1,211.10	242%
2024	Соёлын төвийн барилга /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/	Шилжих	УТ2103400498	2022	2024	2	500.00	1,707.88	1,207.88	242%
2024	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Шилжих	УТ2102000997	2018	2024	6	2,800.00	9,502.64	6,702.64	239%
2024	Спорт заалны барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/	Шилжих	УТ2003150028	2020	2024	4	200.00	661.97	461.97	231%
2024	Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/	Шилжих	УТ1103100002	2011	2024	13	11,041.00	36,360.39	25,319.39	229%
2024	Соёлын төвийн барилга, 200 суудал /Хөвсгөл, Ренчинлүмбэ сум/	Шилжих	УТ2003400749	2020	2025	5	1,400.00	4,600.00	3,200.00	229%
2024	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	Шилжих	УТ2002001025	2019	2024	5	8,752.90	28,656.20	19,903.30	227%
2024	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо/2	Шилжих	УТ2001500498	2020	2024	4	1,800.00	5,751.00	3,951.00	220%
2024	Сургуулийн барилга, 320 суудал /Хэнтий, Жаргалтхаан сум/	Шилжих	УТ2001500533	2020	2024	4	2,473.90	7,735.62	5,261.72	213%
2024	Музей, номын сангийн цогцолбор /Дархан-Уул, Дархан сум/	Шилжих	УТ2003400784	2021	2025	4	5,000.00	15,600.50	10,600.50	212%

2024	Чигис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэл, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/	Шилжих	УТ2002900028	2021	2024	3	5,000.00	15,499.40	10,499.40	210%
2024	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанбайшинт боомт/	Шилжих	УТ2001500451	2020	2024	4	450.00	1,388.49	938.49	209%
2024	Цагдаагийн тасгийн байр /Өвөрхангай, Богд сум/	Шилжих	УТ2101201405	2021	2024	3	300.00	924.13	624.13	208%
2024	Соёл, спортын төвийн барилга, 250 суудал /Төв, Баянжаргалан сум/	Шилжих	УТ2103401414	2020	2024	4	1,200.00	3,648.60	2,448.60	204%
2024	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	Шилжих	УТ2001500426	2020	2024	4	800.00	2,393.75	1,593.75	199%
2024	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Говь-Алтай, Жаргалан сум/	Шилжих	УТ2001500378	2019	2024	5	900.00	2,676.81	1,776.81	197%
2024	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, 145 дугаар цэцэрлэг/	Шилжих	УТ2001500610	2021	2024	3	1,265.00	3,734.59	2,469.59	195%
2024	Спорт заалны барилга, 500 суудал /Говь-Алтай, Цогт сум/	Шилжих	УТ2003100061	2021	2024	3	1,500.00	4,420.20	2,920.20	195%
2024	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/	Шилжих	УТ2001500514	2020	2025	5	1,540.00	4,516.00	2,976.00	193%
2024	Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Шилжих	УТ2102900930	2011	2025	14	2,807.40	8,151.00	5,343.60	190%
2024	Ард Аюушийн өргөн чөлөөний гэрэлтүүлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	Шилжих	УТ2102900983	2022	2024	2	520.00	1,509.76	989.76	190%
2024	Эрдэнэзуу музейн "Аялал жуулчлалын гудамж" төсөл /Өвөрхангай, Хархорин сум/	Шилжих	УТ2001350434	2020	2024	4	1,600.00	4,607.62	3,007.62	188%
2024	Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжлийн сургалтын төвийн барилга /Улаанбаатар/	Шилжих	УТ2100900057	2022	2025	3	4,400.00	12,461.20	8,061.20	183%

2024	Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	Шилжих	УТ2103100224	2019	2024	5	250.00	705.30	455.30	182%
2024	Спорт, урлагийн цогцолбор сургууль, 320 суудал /Хөвсгөл, Мөрөн сум/	Шилжих	УТ2001500504	2020	2025	5	2,500.00	7,003.00	4,503.00	180%
2024	Сургуулийн барилга, 960 суудал /Хөвсгөл, Тариалан сум/	Шилжих	УТ2001500556	2019	2025	6	4,000.00	11,182.63	7,182.63	180%
2024	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	Шилжих	УТ2001500524	2019	2025	6	3,432.90	9,534.60	6,101.70	178%
2024	Спорт заалны барилга /Гев, Жаргалант сум/	Шилжих	УТ2103100001	2021	2024	3	600.00	1,643.30	1,043.30	174%
2024	Цагдаагийн тасгийн байр /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	Шилжих	УТ2101201403	2022	2024	2	380.00	1,040.70	660.70	174%
2024	Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум, Говийн ирээдүй цогцолбор/	Шилжих	УТ2001500586	2021	2025	4	5,496.40	14,726.61	9,230.21	168%
2024	Спорт заалны барилга /Увс, Хяргас сум/	Шилжих	УТ2003100056	2021	2024	3	950.00	2,535.80	1,585.80	167%
2024	Ахмадын сувиллын барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг, 1 дүгээр хороо/	Шилжих	УТ2103900905	2022	2025	3	2,599.90	6,795.18	4,195.28	161%
2024	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 14 дүгээр сургууль/	Шилжих	УТ2101501433	2020	2025	5	3,800.00	9,881.00	6,081.00	160%
2024	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/	Шилжих	УТ2001500605	2021	2024	3	750.00	1,924.00	1,174.00	157%
2024	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Говь-Алтай, Төгрөг сум/	Шилжих	УТ2001500379	2019	2024	5	900.00	2,294.43	1,394.43	155%
2024	Бага сургуулийн барилга, 360 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум, Тыва бага сургууль/	Шилжих	УТ2101500094	2019	2024	5	1,200.00	3,051.31	1,851.31	154%
2024	Нийслэлийн 2 дугаар төрөх "Хүрээ амаржих" газрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	Шилжих	УТ2102000823	2022	2024	2	18,031.40	45,472.64	27,441.24	152%
2024	Ахмадын сувиллын барилга /Булган, Хишиг-Өндөр сум/	Шилжих	УТ2103900173	2021	2025	4	1,250.00	3,124.99	1,874.99	150%

2024	Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Биндэр сум/	Шилжих	УТ2101501414	2020	2025	5	500.00	1,245.73	745.73	149%
2024	Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Шилжих	УТ2102900759	2019	2024	5	4,000.00	9,888.33	5,888.33	147%
2024	Сургуулийн барилгын өргөтгөл, 120 суудал /Өвөрхангай, Уянга сум, Жаргалант баг/	Шилжих	УТ2001500622	2021	2024	3	1,000.00	2,470.10	1,470.10	147%
2024	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо/	Шилжих	УТ2001500029	2021	2024	3	2,500.00	6,059.86	3,559.86	142%
2024	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр сургууль/	Шилжих	УТ2001500506	2018	2024	6	3,266.80	7,891.04	4,624.24	142%
2024	Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	Шилжих	УТ2101501199	2022	2024	2	3,000.00	7,226.70	4,226.70	141%
2024	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 108 дугаар цэцэрлэг/	Шилжих	УТ2101500921	2022	2025	3	2,910.00	6,956.21	4,046.21	139%
2024	Хорооны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 39, 43 дугаар хороо/	Шилжих	УТ2201011381	2022	2024	2	2,000.00	4,768.58	2,768.58	138%
2024	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум, 2 дугаар сургууль/	Шилжих	УТ2001500641	2021	2024	3	1,000.00	2,377.20	1,377.20	138%
2024	Соёлын төвийн барилга, 240 суудал /Хөвсгөл, Арбулаг сум/	Шилжих	УТ2003400755	2019	2024	5	1,230.00	2,923.10	1,693.10	138%
2024	Цагдаагийн тасгийн байр /Хэнтий, Баян-Овоо сум/	Шилжих	УТ2101201404	2022	2024	2	380.00	890.77	510.77	134%
2024	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	Шилжих	УТ2001553561	2020	2025	5	4,000.00	9,371.92	5,371.92	134%
2024	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Баяннуур сум, "Ак арал" баг/	Шилжих	УТ2101500118	2020	2024	4	380.00	885.85	505.85	133%
2024	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Дарьганга сум/	Шилжих	УТ2001500642	2021	2024	3	1,600.00	3,648.91	2,048.91	128%

2024	Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/	Шилжих	УТ1903400003	2019	2024	5	6,800.00	15,373.60	8,573.60	126%
2024	Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/	Шилжих	УТ2101101145	2022	2024	2	8,000.00	18,000.00	10,000.00	125%
2024	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/	Шилжих	УТ2001500478	2019	2024	5	500.00	1,120.28	620.28	124%
2024	Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум/	Шилжих	УТ1903400004	2019	2025	6	1,100.00	2,459.87	1,359.87	124%
2024	Дотуур байрны барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	Шилжих	УТ2001500499	2020	2024	4	1,000.00	2,222.76	1,222.76	122%
2024	Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/	Шилжих	УТ2103401202	2022	2025	3	2,453.80	5,432.90	2,979.10	121%
2024	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Цахир сум/	Шилжих	УТ2001500522	2019	2024	5	3,200.00	7,082.59	3,882.59	121%
2024	Ахмадын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	Шилжих	УТ2003900009	2021	2024	3	1,000.00	2,207.80	1,207.80	121%
2024	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/	Шилжих	УТ2001500434	2020	2024	4	1,750.00	3,863.55	2,113.55	121%
2024	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/	Шилжих	УТ2101500879	2021	2024	3	1,750.00	3,851.89	2,101.89	120%
2024	Спорт заалны барилга /Баянхонгор, Шинэжинст сум/	Шилжих	УТ2003100018	2020	2024	4	550.00	1,206.60	656.60	119%
2024	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	Шилжих	УТ2002000013	2021	2024	3	900.00	1,953.00	1,053.00	117%
2024	Залуучуудын хөгжлийн ордны барилга /Сэлэнгэ, Сайхан сум/	Шилжих	УТ2003900006	2021	2024	3	1,100.00	2,370.10	1,270.10	115%
2024	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхланта сум/	Шилжих	УТ2102000623	2020	2024	4	284.20	608.49	324.29	114%
2024	Үндэсний номын сангийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	Шилжих	УТ2103400810	2012	2024	12	12,000.00	25,671.35	13,671.35	114%
2024	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/	Шилжих	УТ2002900059	2021	2024	3	300.00	641.20	341.20	114%

2024	Усан сан /Өвөрхангай, Баянгол сум/	Шилжих	УТ2101900514	2020	2024	4	80.00	170.23	90.23	113%
2024	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	Шилжих	УТ1902000017	2019	2024	5	500.00	1,063.50	563.50	113%
2024	Сургуулийн барилга, 640 суудал /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	Шилжих	УТ2001500537	2019	2025	6	5,000.00	10,597.70	5,597.70	112%
2024	Дүүргийн соёлын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	Шилжих	УТ2003400775	2019	2024	5	8,500.00	17,964.26	9,464.26	111%
2024	Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/	Шилжих	УТ2101900552	2020	2024	4	1,400.00	2,949.10	1,549.10	111%
2024	Дэлүүн болдог нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум/	Шилжих	УТ2002800921	2020	2024	4	5,000.00	10,484.16	5,484.16	110%
2024	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	Шилжих	УТ2102000205	2022	2024	2	2,100.00	4,377.80	2,277.80	108%
2024	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 7, 8, 13 дугаар баг/	Шилжих	УТ2002000019	2021	2024	3	400.00	819.80	419.80	105%
2024	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/	Шилжих	УТ2001500618	2021	2024	3	1,400.00	2,843.20	1,443.20	103%
2024	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 23 дугаар хороо/	Шилжих	УТ2001500541	2020	2024	4	3,315.00	6,717.84	3,402.84	103%
2024	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, 49 дүгээр цэцэрлэг/	Шилжих	УТ2101500826	2022	2024	2	2,800.00	5,673.53	2,873.53	103%
2024	Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Батцэнгэл сум/	Шилжих	УТ2301514893	2021	2024	3	3,000.00	6,066.41	3,066.41	102%
2024	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	Шилжих	УТ2003450835	2020	2024	4	1,617.80	3,270.80	1,653.00	102%
2024	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 71 дүгээр цэцэрлэг/	Шилжих	УТ2001550760	2020	2024	4	1,536.00	3,098.19	1,562.19	102%

2024	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 120 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 67 дугаар цэцэрлэг/	Шилжих	УТ2001500028	2021	2024	3	1,500.00	3,020.00	1,520.00	101%
2024	Дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Даланзадгад сум/	Шилжих	УТ21015000524	2022	2025	3	2,274.20	4,559.14	2,284.94	100%
2024	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, спорт заал, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 3 дугаар сургууль/	Шилжих	УТ21015000445	2022	2025	3	8,233.10	16,489.27	8,256.17	100%
2024	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	Шилжих	УТ20029000061	2021	2024	3	5,000.00	9,960.80	4,960.80	99%
2024	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	Шилжих	УТ2101501038	2020	2024	4	3,500.00	6,950.98	3,450.98	99%
2024	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо/	Шилжих	УТ20015000530	2019	2024	5	2,500.00	4,937.32	2,437.32	97%
2024	Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	Шилжих	УТ2202011658	2022	2025	3	2,800.00	5,521.36	2,721.36	97%
2024	Эрээнцавын шалган нэвтрүүлэх заставын өргөтгөл, хилийн отряд шинээр байгуулах /Дорнод, Чулуунхороот сум/	Шилжих	УТ21012000334	2021	2024	3	6,000.00	11,822.50	5,822.50	97%
2024	Биеийн тамир, хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13, 15, 16 дугаар хороо/	Шилжих	УТ21029000436	2022	2024	2	1,250.00	2,453.36	1,203.36	96%
2026	Ухаалаг худаг бүхий нийтийн халуун усны барилга /Увс, Зүүнхангай сум/	Шилжих	УТ2002900057	2021	2026	5	340.00	552.80	212.80	63%
2026	Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	Шилжих	УТ2401502492	2024	2026	2	3,469.60	5,580.60	2,111.00	61%
2026	Дотуур байрны барилга, 40 ор, гал тогооны хамт /Хэнтий, Баянхутаг сум/	Шилжих	УТ2001500596	2021	2026	5	900.00	1,430.60	530.60	59%
2026	Музейн дотоод интерьер /Өвөрхангай, Арвайхээр сум/	Шилжих	УТ2403401128	2024	2026	2	1,000.00	1,575.90	575.90	58%
2026	Сургуулийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 9 дүгээр хороо, 76 дугаар сургууль/	Шилжих	УТ2001500386	2020	2026	6	2,000.00	3,110.80	1,110.80	56%
2026	Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Бор-Өндөр сум/	Шилжих	УТ211901356	2022	2026	4	4,400.00	6,809.50	2,409.50	55%
2026	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Жаргалант сум, 5 дугаар баг/	Шилжих	УТ2101501257	2022	2026	4	10,123.00	15,532.20	5,409.20	53%

2026	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Төв, Заамар сум/	Шилжих	УТ201400578	2020	2026	6	1,500.00	2,296.80	796.80	53%
2026	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	Шилжих	УТ2101500266	2019	2026	7	1,619.20	2,471.30	852.10	53%
2026	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/	Шилжих	УТ2401502527	2024	2026	2	600.00	914.60	314.60	52%
2026	Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Архангай, Эрдэнэбулган сум/	Шилжих	УТ202001027	2020	2026	6	17,000.00	25,904.60	8,904.60	52%
2026	Сургуулийн барилга, 640 суудал /ГовьАлтай, Есөнбулаг сум, Хантайшир-Эрдэм цогцолбор/	Шилжих	УТ2401502391	2024	2027	3	11,748.70	17,731.90	5,983.20	51%
2026	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/	Шилжих	УТ2103100369	2022	2027	5	13,000.00	19,263.20	6,263.20	48%
2026	Сургуулийн барилга, 960 суудал /Өмнөговь, Цогтэций сум/	Шилжих	УТ201400551	2019	2027	8	6,713.60	9,815.70	3,102.10	46%
2026	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо/	Шилжих	УТ2001552001	2018	2026	8	1,849.10	2,684.40	835.30	45%
2026	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны барилга, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум/	Шилжих	УТ2401502382	2024	2026	2	4,569.50	6,604.50	2,035.00	45%
2026	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 11 дүгээр баг/	Шилжих	УТ2101500348	2022	2026	4	3,040.00	4,368.00	1,328.00	44%
2026	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг/	Шилжих	УТ2401502528	2024	2026	2	600.00	854.10	254.10	42%

2026	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Дархан-Уул, Дархан сум/	Шилжих	УТ2401502616	2024	2027	3	11,482.30	16,268.20	4,785.90	42%
2026	Спортын ордны барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	Шилжих	УТ200300002	2021	2026	5	7,900.00	11,120.70	3,220.70	41%
2026	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 12 дугаар баг/	Шилжих	УТ2001500606	2021	2026	5	1,500.00	2,102.20	602.20	40%
2026	Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/	Шилжих	УТ2101500070	2022	2026	4	2,300.00	3,208.40	908.40	39%
2026	Цагдаагийн газрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	Шилжих	УТ2201211464	2022	2026	4	5,400.00	7,404.60	2,004.60	37%
2026	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Шилжих	УТ2402002233	2024	2026	2	3,427.70	4,685.40	1,257.70	37%
2026	Спорт заалны барилга /Сэлэнгэ, Орхон сум, 1 дүгээр баг/	Шилжих	УТ2403100368	2024	2026	2	1,871.70	2,554.20	682.50	36%
2026	Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/	Шилжих	УТ211701201	2018	2026	8	5,000.00	6,721.00	1,721.00	34%
2026	Сургуулийн барилга, 320 суудал /Говь-Алтай, Цээл сум/	Шилжих	УТ2001500632	2021	2026	5	3,938.50	5,172.60	1,234.10	31%
2026	Спорт заалны барилга /Сэлэнгэ, Жавхланта сум/	Шилжих	УТ2403100367	2024	2027	3	1,871.70	2,455.50	583.80	31%
2026	Спорт заалны барилга /Увс, Цагаанхайрхан сум/	Шилжих	УТ2403400492	2024	2027	3	2,554.80	3,340.20	785.40	31%
2026	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Дорнод, Хэрлэн сум, Шинэ Хөгжил сургууль/	Шилжих	УТ2401502405	2024	2027	3	9,507.70	12,030.50	2,522.80	27%
2026	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 120 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 6 дугаар цэцэрлэг/	Шилжих	УТ2401502393	2024	2026	2	3,001.40	3,770.50	769.10	26%

2026	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 10 км /Говь-Алтай, Есөнбулаг сум/	Шилжих	УТ2102800193	2022	2026	4	10,001.90	12,466.40	2,464.50	25%
2026	Сургуулийн барилгын өргөтгөл, 120 суудал /Булган, Баяннуур сум/	Шилжих	УТ2401502590	2024	2026	2	1,700.00	2,114.40	414.40	24%
2026	Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, иж бүрэн хөл бөмбөгийн талбай /Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль/	Шилжих	УТ2401502432	2024	2027	3	10,000.00	12,339.70	2,339.70	23%
2026	Сургуулийн барилгын өргөтгөл, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/	Шилжих	УТ2401502371	2024	2026	2	3,607.10	4,402.50	795.40	22%
2026	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	Шилжих	УТ2401502435	2024	2026	2	3,473.80	4,188.80	715.00	21%
2026	Соёлын төвийн барилга, 150 суудал /Говь-Алтай, Бугат сум/	Шилжих	УТ211400216	2019	2026	7	1,600.00	1,925.30	325.30	20%
2026	Сургуулийн барилга, 640 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум, 3 дугаар сургууль/	Шилжих	УТ2401502420	2024	2027	3	14,915.00	17,903.50	2,988.50	20%
2026	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг, 5 дугаар хороо/	Шилжих	УТ2101500798	2022	2026	4	9,723.50	11,624.30	1,900.80	20%
2026	Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/	Шилжих	УТ2403100364	2024	2027	3	19,113.30	22,438.00	3,324.70	17%
2026	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга /Дорноговь, Сайншанд сум/	Шилжих	УТ2401502400	2024	2027	3	25,101.60	28,973.70	3,872.10	15%
2026	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр /Баянхонгор, Баянхонгор сум/	Шилжих	УТ2402901608	2024	2026	2	1,000.00	1,132.10	132.10	13%

2026	Сургуулийн спорт заалны барилга /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	Шилжих	УТ2401502618	2024	2026	2	2,000.00	2,247.50	247.50	12%
2026	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Дарви сум/	Шилжих	УТ200300021	2020	2026	6	1,300.00	1,451.40	151.40	12%
2026	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/	Шилжих	УТ2401502472	2024	2026	2	2,850.00	3,181.80	331.80	12%
2026	Дотуур байрны барилга, 100 ор /Говь-Алтай, Халиун сум, 2 дугаар баг/	Шилжих	УТ211300214	2022	2027	5	2,880.10	3,192.90	312.80	11%
2026	Дотуур байрны барилга, 150 ор /Хөвсгөл, Цагаан-Уул сум, 6 дугаар баг/	Шилжих	УТ2101501271	2022	2026	4	2,911.80	3,205.70	293.90	10%
2026	Хабитат, Мангирт чиглэлийн дулаан хангамжийн 2 дугаар контур /Дархан-Уул, Дархан сум, 15 дугаар баг/	Шилжих	УТ2102900275	2022	2026	4	7,646.50	8,339.30	692.80	9%
2026	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/	Шилжих	УТ2401502414	2024	2028	4	15,795.20	17,048.30	1,253.10	8%
2026	Дотуур байрны барилга, 120 ор /Архангай, Өгийнуур сум/	Шилжих	УТ211300030	2019	2026	7	1,500.00	1,618.40	118.40	8%
2026	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, 4 дүгээр цэцэрлэг/	Шилжих	УТ2401502553	2024	2026	2	3,473.90	3,701.70	227.80	7%
2026	Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	Шилжих	УТ2401502477	2024	2026	2	2,850.70	3,011.20	160.50	6%
2026	Дотуур байрны барилга, 100 ор /Завхан, Цэцэн-Уул сум/	Шилжих	УТ211300403	2022	2026	4	2,880.10	3,024.00	143.90	5%
2026	Сургуулийн барилга, 640 суудал, дотуур байрны барилга, 100 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/	Шилжих	УТ2401501789	2024	2027	3	19,015.10	19,932.30	917.20	5%

2026	Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц, 2 дугаар хэлхээ /Говьсүмбэр, Сүмбэр сум/	Шилжих	УТ2403000704	2024	2026	2	11,575.60	12,089.10	513.50	4%
2026	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Сант сум/	Шилжих	УТ2401502471	2024	2026	2	2,850.70	2,931.50	80.80	3%
2026	Дотуур байрны барилга, 150 ор /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	Шилжих	УТ2401502556	2024	2027	3	3,000.00	3,074.50	74.50	2%
	<b>НИЙТ</b>						<b>524,850.20</b>	<b>888,926.10</b>	<b>364,075.90</b>	

## Ашигласан материал

1. Сангийн сайдаас УИХ-ын гишүүн Б.Пунсалмаад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/8472 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн мэдээлэл, БХТ-өөс ирүүлсэн УТХО-аар санхүүжүүлсэн ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдэж буй шалтгааны талаарх танилцуулга мэдээлэл,
3. БХТ-өөс ирүүлсэн ТАХ-ний төсөвт өртгийг өөрчлөн магадлал хийх процесс ажиглаганы диаграм
4. УАГ-ийн аудитын тайлан. Аудитын сэдэв: "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн. Аудитын код: ГНАГ-2024/18-ШТА-ГА
5. УАГ-ийн тайлан. Аудитын сэдэв: "Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах". Аудитын код: ГНАГ-2023/15-ШТА-НА
6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт
7. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
8. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
9. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2026 ОН**

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Тогтоолын төслийн үр нөлөөний үнэлгээг “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийн /цаашид “Тогтоолын төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасны дагуу хуулийн төслийн зүйл, заалтын харилцан уялдаа, практикт хэрэгжих боломж, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийсэн болно.

Тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг дараах үе шаттайгаар хийлээ.

1. Тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Тогтоолын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## ХОЁР. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэхдээ дараах 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр тогтоолоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
5. Зардал
6. Харилцан уялдаа

**Зорилгод хүрэх байдал** хэмээх шалгуур үзүүлэлтийг тогтоолын төслийн зохицуулалт нь түүнийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэх, мөн зорилгыг тодорхой илэрхийлсэн эсэхийг тогтоох зорилгоор сонгов.

**Практикт хэрэгжих боломж** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдсэн эсэхийг тогтоох зорилгоор сонгов.

**Ойлгомжтой байдал** хэмээх шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдэд ойлгомжтой, тодорхой эсэх, мөн нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд холбогдох хууль тогтоомж, аргачлалын шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох зорилгоор сонгов.

**Хүлээн зөвшөөрөгдөх байдал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалт нь иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх боломжийг үнэлэх зорилгоор сонгов.

**Зардал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг тодорхойлох, түүнээс гарах үр дагаврыг тооцох зорилгоор сонгосон болно.

**Харилцан уялдаа** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалт нь бусад хууль тогтоомж болон дагалдах хуулийн төслүүдтэй хэрхэн уялдаж байгааг тогтоох үүднээс сонгосон болно.

## **ГУРАВ. ТОГТООЛЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

**Зорилгод хүрэх байдал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалт нь түүнийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа эсэх, мөн зорилгыг тодорхой илэрхийлсэн эсэхийг тогтоох зорилгоор тогтоолын төслийн 1–4 дүгээр заалт, түүнчлэн 1 дүгээр заалтын 5 дэд заалтыг хамруулан авч үзэв.

**Практикт хэрэгжих боломж** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдсэн эсэхийг тогтоох зорилгоор тогтоолын төслийг бүхэлд нь хамруулан авч үзэв.

*/Тогтоолын төсөл 4 заалттай ба 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалттай./*

**Ойлгомжтой байдал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдэд ойлгомжтой, тодорхой эсэх, мөн бичвэр нь нэр томьёо, хэл зүй, найруулгын хувьд холбогдох хууль тогтоомж, аргачлалын шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох зорилгоор тогтоолын төслийг бүхэлд нь хамруулан авч үзэв.

*/Тогтоолын төсөл 4 заалттай ба 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалттай./*

**Хүлээн зөвшөөрөгдөх байдал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалт нь иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх боломжийг үнэлэх зорилгоор тогтоолын төслийг бүхэлд нь хамруулан авч үзэв.

*/Тогтоолын төсөл 4 заалттай ба 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалттай./*

**Зардал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт үүсэх зардал, ачааллыг тодорхойлох, түүнээс гарах үр дагаврыг тооцох зорилгоор тогтоолын төслийг бүхэлд нь хамруулан авч үзэв.

*/Тогтоолын төсөл 4 заалттай ба 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалттай./*

**Харилцан уялдаа** шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалт нь бусад хууль тогтоомж болон дагалдах хуулийн төслүүдтэй хэрхэн уялдаж байгааг тогтоох зорилгоор тогтоолын төслийг бүхэлд нь, холбогдох хуулийн төслүүдийн хамт авч үзэв.

*/Тогтоолын төсөл 4 заалттай ба 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалттай./*

## **ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатанд тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, үнэлгээ хийх хүрээг тогтоосон. Үүний дагуу тухайн шалгуур үзүүлэлт бүрт нийцсэн шалгах хэрэгслийг тодорхойлон, дараах байдлаар авч үзэв.

Хүснэгт 1.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төсөл 4 заалттай болон 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалт	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	Тогтоолын төсөл 4 заалттай болон 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалт	Практикт турших
3.	Ойлгомжтой байдал	Тогтоолын төсөл 4 заалттай болон 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалт	Ойлгомжтой байдлыг шалгах
4.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Тогтоолын төсөл 4 заалттай болон 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалт	Хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг шалгах.
5.	Зардал	Тогтоолын төсөл 4 заалттай болон 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалт	Зардлын тооцоо хийх
6.	Харилцан уялдаа	Тогтоолын төсөл 4 заалттай болон 1 дүгээр заалт нь дотроо 5 дэд заалт	Тогтоолын төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх хүснэгтэд тусгасан шалгуур үзүүлэлт, түүнд нийцсэн шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

### **1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Тогтоолын төслийн үзэл баримтлалд “улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх; төсөвт өртөгийн өсөлтийг бууруулах; зогссон, удааширсан төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх; төлөвлөлт, шийдвэр гаргалтыг ил тод, өгөгдөлд суурилсан болгох; төсвийн сахилга, хариуцлагыг бэхжүүлэхэд оршино.” гэжээ.

Тогтоолын төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй барилга байгууламж бүхий төсөл арга хэмжээ хугацаандаа орохгүй саатаж буй болон анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлан, жил бүрийн улсын төсөвт дарамт үүсгэж буй шалтгааныг авч үзэх, тэдгээртэй холбоотой асуудлыг зохицуулах, хяналт тавих асуудлыг тусгасан байна. Ингэснээр тогтоолын төслийн үзэл баримтлал болон тухайн тогтоолын зорилгод нийцсэн болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр тогтоолын төслийг бүхэлд нь (4 заалт болон 1 дүгээр заалтад багтах 5 дэд заалт) сонгосон болно.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл, арга хэмжээнүүдийн талаар судалж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар, улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ бүрээр тус бүр үнэлж, тайланг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

2/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хэдий ч дуусгалгүй зогсоосон, цаашид улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар төр, хувийн хэвшилд шилжүүлэх санал, дүгнэлтийг нэг бүрчлэн гаргаж 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах;

3/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээ хугацаандаа орохгүй саатаж буй болон анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлан, төсөвт дарамт үүсгэж буй шалтгааныг арилгах арга хэмжээ авах;

4/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг бодит цагийн байдлаар харах, ашиглах, боломжоор хангах, мэдээллийг нэгтгэн системчлэх, стандартчилах;

5/ Улсын Их Хурлаар улсын жилийн төсөв хэлэлцэн батлах хугацаанд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29<sup>1.4</sup> -т заасан систем дэх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд бүхэлд нь харах боломжоор хангах.

/"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслөөс/

Тогтоолын төслийн зорилтод төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төсөвт өртгийн хэт өсөлтийг бууруулах, зогссон болон удааширсан төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, цэгцлэх мөн төлөвлөлт, хяналтын тогтолцоог сайжруулах асуудлыг тусгасан байна.

Дээрх асуудлын шалтгааныг тодорхойлон бодлогын арга хэмжээ авах зэрэг зорилтот арга хэмжээнүүдийг тусгажээ. Тухайлбал; Тогтоолын төслийн 1.3-т "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээ хугацаандаа орохгүй саатаж буй болон анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлан, төсөвт дарамт үүсгэж буй шалтгааныг

арилгах арга хэмжээ авах”, 1.4-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг бодит цагийн байдлаар харах, ашиглах, боломжоор хангах, мэдээллийг нэгтгэн системчлэх, стандартчилах”, 1.5-т “Улсын Их Хурлаар улсын жилийн төсөв хэлэлцэн батлах хугацаанд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29<sup>1.4</sup> -т заасан систем дэх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд бүхэлд нь харах боломжоор хангах” гэсэн байна.

Иймд дээрх зохицуулалтууд нь зорилгод хүрэхэд чиглэсэн бодит бөгөөд хэрэгжих боломжтой механизмыг агуулсан гэж үзэж, тогтоолын төсөл нь зорилгод хүрэх боломжтой байна.

## **2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Тогтоолын төслийн үзэл баримтлалд “... дээрх нөхцөл байдал өнөөг хүртэл засагдалгүй үргэлжилж, улсын төсөвт их хэмжээний санхүүгийн дарамт үүсгэж байгаа тул уг асуудлыг Засгийн газрын түвшинд судлан, санал, дүгнэлт гаргаж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлаас чиглэл өгөх шаардлага үүсээд байна.” гэж тусгасан байна.

Тогтоолын төслийг хэрэгжүүлэх үндсэн субъект нь Засгийн газар, холбогдох салбарын яамд, төсвийн ерөнхийлөн захирагчид байна.

Хэрэгжилтийн нөхцөлийн хувьд одоогийн эрх зүйн орчин нь тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд саад учруулахгүй бөгөөд шинээр хууль санаачлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна. Харин хэрэгжилтийн явцад мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл хангалтгүй, судалгааны чанар харилцан адилгүй, мөн улс төрийн нөлөөлөл үүсэх эрсдэл зэрэг хүндрэл, сорилтууд тулгарч болзошгүй байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэхэд тогтоолын төслийг богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой бөгөөд практикт хэрэгжих боломжтой гэж үнэлж байна.

## **3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхэд тогтоолын төслийн бүтэц логик дараалалтай, заалт, дэд заалтуудын уялдаа холбоо тодорхой байна. Түүнчлэн хэрэгжүүлэх үүрэг, чиглэлүүдийг тодорхой зааглаж, хэрэгжилтийн хугацаа болон хариуцах субъектүүдийг тодорхой тусгасан нь төслийн агуулгыг ойлгомжтой болгож байна. Мөн тогтоолын төслийн бичвэр нь нэр томъёоны хэрэглээ, хэл зүй, найруулгын хувьд нэг мөр, тодорхой бөгөөд давхардал, хийсвэр ойлголт бага, хэрэгжүүлэгч болон шийдвэр гаргагч талуудад нэгэн адил ойлгогдохоор байна. Тухайлбал; Тогтоолын төслийн 1.1-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл, арга хэмжээнүүдийн талаар судалж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар, улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ бүрээр тус бүр үнэлж, тайланг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах”, 1.2-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хэдий ч дуусгалгүй зогсоосон, цаашид улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн

санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар төр, хувийн хэвшилд шилжүүлэх санал, дүгнэлтийг нэг бүрчлэн гаргаж 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах” гэсэн байна.

Иймд тогтоолын төсөл нь ойлгомжтой байдлын шаардлагыг хангасан, хэрэгжилтийн явцад тайлбарлах, нэмэлт тодруулга шаардах нөхцөл харьцангуй бага байна гэж үзэж байна.

#### **4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд оролцогч талуудын байр суурийг авч үзэхэд Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн ХЭГ/82 дугаартай албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг ирүүлсэн. Уг тэмдэглэлийн Засгийн газраас өгөх санал дүгнэлтээр тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж буйгаа уламжилсан.

Мөн олон нийтийн хэлэлцүүлэгт оролцсон төрийн байгууллагууд болон холбогдох мэргэжлийн холбоодын зүгээс тогтоолын төслийг дэмжсэнээр төсвийн хөрөнгө оруулалтын хяналт сайжрах, шийдвэр гаргалтын ил тод байдал нэмэгдэх, үр ашгийг дээшлүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Иргэд, олон нийтийн байгууллагуудын хувьд төсвийн зарцуулалтын үр ашиг сайжрах, хариуцлагын тогтолцоо бэхжих замаар уг тогтоолын төслийг дэмжих хандлага давамгайлах төлөвтэй байна. Харин төсөл хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч зарим байгууллагуудын хувьд хяналт, үнэлгээний шаардлага нэмэгдэх, хариуцлагын тогтолцоо чанарахтай холбоотойгоор тодорхой хэмжээнд тэдэнд эрсдэл үүсэхийг үгүйсгэхгүй.

Нийгмийн хүлээлтийн хувьд төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын үр ашиг сайжирч, ил тод байдал нэмэгдэх төсвийн сахилга бат, хариуцлага дээшлэх нөхцөл бүрдэх тул олон нийтийн дэмжлэг авах боломжтой гэж үзэж байна.

Нийгэм, эдийн засгийн үзүүлэх үр нөлөөгөөр авч үзвэл энэхүү тогтоолын төсөл нь төсвийн сахилга бат, төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн байх тул иргэд төрийн болон нийтийн үйлчилгээ цаг алдалгүй авах боломж бүрдэж, Үндсэн хуулиар олгосон эрх хангагдаж өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой.

#### **5. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Энэхүү тогтоолын төсөл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн зардлын зөв хуваарилалт хийхэд чиглэсэн агуулгатай бөгөөд хэрэгжилтийн үр дүнд төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын орон зай нэмэгдэх, төсвийн хөрөнгийн хэмнэлт бий болох боломжтой байна.

Тодруулбал, төсөвт өртгийн хэт өсөлт буурах, давхардсан болон үр ашиггүй зардлыг багасгах, мөн удаан хугацаанд гацсан төслүүдтэй холбоотой зардлыг оновчтой болгох, зарим тохиолдолд хэмнэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Гэвч дээрх судалгаа, үнэлгээг хийхэд захиргааны тодорхой хэмжээний зардал гарах магадлалтай. Төрийн байгууллагууд өөрийн батлагдсан төсвийн хүрээнд эдгээр судалгаа, үнэлгээг нэмэлт зардал гаргахгүйгээр өөрөө бие даан хийх бүрэн боломжтой гэж харж байна.

Иймд тогтоолын төслийн хэрэгжилт нь богино болон дунд хугацаанд төсвийн сахилга батыг сайжруулах, урт хугацаанд нийгэм, эдийн засгийн хувьд өндөр үр ашиг бий болгох ач холбогдолтой.

#### **6. “Тогтоолын төслийн харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцтэй бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуультай уялдаатай боловсруулсан байна.

Түүнчлэн уг тогтоолын төсөл нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжтой давхардал үүсгэхгүй, харин төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх шинжтэй байна.

Иймд энэхүү тогтоолын төсөл нь эрх зүйн орчны уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

#### **ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл батлагдсанаар төсөвт өртгийн хэт өсөлтийг бууруулах, зогссон болон удааширсан төслүүдийг цэгцлэх, мөн шийдвэр гаргалтыг өгөгдөлд суурилсан, ил тод, хариуцлагатай болгох бодит боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Цаашид удааширсан төслүүдийг нэгдсэн байдлаар үнэлж, хэрэгжилтийн байдлаас хамааран гүйцээн дуусгах, зогсоох, эсхүл хувьчлах (төр, хувийн хэвшлийн түншлэл) гэсэн хэлбэрээр ангилан шийдвэрлэх шаардлагатай байна. Мөн шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавих шалгуур, шаардлагыг сайжруулж, үнэлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад энэ хүрээнд Засгийн газар болон Улсын Их Хурал онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Ялангуяа Улсын Их Хурлын гишүүд манлайлал үзүүлэн ажиллах хэрэгтэй.

Эдийн засгийн хувьд уг тогтоолын төсөл хэрэгжсэнээр төсвийн үр ашиг нэмэгдэж, илүүдэл болон үр ашиггүй зардал буурах нөхцөл бүрдэнэ. Нийгмийн хувьд иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, бүтээн байгуулалтын ажлууд хугацаандаа ашиглалтад орох боломж нэмэгдэнэ.

Төсвийн удирдлагын хувьд зардлын өсөлт хязгаарлагдаж, ил тод байдал болон хариуцлагын тогтолцоо сайжрах үр нөлөөтэй байна. Харин захиргааны хувьд

байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт бэхжих эерэг ач холбогдолтой гэж үзэж байна.

### **ЗӨВЛӨМЖ**

Үр нөлөөний үнэлгээний дүнг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Зогссон болон удаашралтай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар үнэлж, эрэмбэлэн ангилж (дуусгах, зогсоох, эсхүл хувьчлах) шийдвэрлэх эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой болгох;
2. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн сонгон шалгаруулалт, төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг сайжруулж, үр ашиг, өгөөжид суурилсан үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх;
3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, тогтмол шинэчлэгддэг, ил тод, шийдвэр гаргалтад ашиглагдах боломжтой системийг хөгжүүлэх; Учир нь одоо ашиглаж буй систем шийдвэр гаргагч Улсын Их Хурлын гишүүдэд хаалттай байна.
4. Төсвийн хөрөнгө оруулалтын хяналт, тайлагналын тогтолцоог сайжруулж, олон шатлалт хяналтын механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх;
5. Төсөвт өртгийн хэт өсөлт, давхардлыг бууруулах зорилгоор хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, холбогдох байгууллагуудын уялдаа, хариуцлагыг нэмэгдүүлэх;
6. Улсын Их Хурал болон Засгийн газар нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

---ooOoo---

## **Ашигласан материал**

1. Сангийн сайдаас УИХ-ын гишүүн Б.Пунсалмаад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/8472 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн мэдээлэл,
2. БХТ-өөс ирүүлсэн УТХО-аар санхүүжүүлсэн ТАХ-ний төсөвт өртөг нэмэгдэж буй шалтгааны талаарх танилцуулга мэдээлэл,
3. БХТ-өөс ирүүлсэн ТАХ-ний төсөвт өртгийг өөрчлөн магадлал хийх процесс ажиллагааны диаграмм
4. ҮАГ-ийн аудитын тайлан. Аудитын сэдэв: “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн. Аудитын код: ГНАГ-2024/18-ШТА-ГА
5. ҮАГ-ийн тайлан. Аудитын сэдэв: “Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах”. Аудитын код: ГНАГ-2023/15-ШТА-НА
6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт*
7. *Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт*. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
8. *Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт*. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
9. *Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт*. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## Нэг. Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хууль<sup>1</sup>-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /цаашид “тогтоолын төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд

- иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;<sup>2</sup>
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;<sup>3</sup>
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;<sup>4</sup>
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.<sup>5</sup>

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог. Харин тус хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй тул аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

<sup>1</sup> 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11119>

<sup>2</sup> Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

<sup>3</sup> Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

<sup>4</sup> Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

<sup>5</sup> Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

**Хоёр. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо**

Энэ хэсэгт тогтоолын төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас ямар нэг нэмэлт ажиллагаа хийгдэхгүй бөгөөд аливаа зардал үүсэхгүй болно.

Тогтоолын төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгосон зохицуулалт байхгүй байна.

**Гурав. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлын тооцоо**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан иргэнд шинээр гүйцэтгэх үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгох зохицуулалт байхгүй байна.

**Дөрөв. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлсэн зохицуулалт тусгаагүй тул улсын төсөвт шинээр зардал үүсэхээргүй байна.

---oOo---



...

БҮГД

ЕРӨНЖИЙ ЛӨГЧ

УИХ-ЫН ГИШҮҮД

ЗАСГИЙН ГАЗАР

БУСАД

АГ ДҮН ШИНЖИЛГЭЭ

## БОЛОВСРУУЛЖ БҮЙ ТЭСЛҮҮД

ХӨЙТ...

Q

АЯ В



УИХ-ЫН ГИШҮҮЧ

Бадамдоржийн ПУНСАЛМАА

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА  
ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ  
ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ

САНХҮҮЖҮҮ

217

04

2025.12.23

## **“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг иргэд, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлсэн байдал**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хуульд заасны дагуу нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтийн санал авах зорилгоор D-Parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

### **Нэг. Хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай**

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг олон талын оролцоонд тулгуурлан боловсронгуй болгох зорилгоор мэргэжлийн байгууллага, холбоод, холбогдох мэргэжилтнүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд 41 мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан болно.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа; Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Р.Даваадорж; Үндэсний аудитын газар; “Төсвийн тогтвортой байдлын зөвлөл”-ийн ажлын алба; Сангийн яам; Эдийн засаг, хөгжлийн яам; Боловсролын яам, Хот Байгуулалт, Барилга Орон Сууцжуулалтын Яам; Барилгын хөгжлийн төв; “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” болон гишүүн байгууллагууд; Монголын Барилгын Үндэсний Ассоциаци; -ийн төлөөллүүд оролцлоо. Хэлэлцүүлгийн модиратороор Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Д.Амарбаясгалан ажиллаа. Дээрх холбогдох мэргэжилтнүүдээс 21 оролцогч асуулт асууж, үг хэлж, санал гаргасныг дараах байдлаар нэгтгэн дүгнэв.

### **Хэлэлцүүлгээр хөндөгдсөн асуудал**

Хэлэлцүүлгийн явцад оролцогчид улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын тогтолцоонд дараах нийтлэг асуудлууд байгааг онцлон тэмдэглэв. Үүнд:

#### **1. Төлөвлөлтийн шатанд**

- Төсвийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хангалтгүй, бэлтгэл ажил дутуу, судалгаанд суурилагагүй төсөл, арга хэмжээг олноор тусгаж байгаа;
- Шинээр эхлүүлэх төсөлд анхаарал хэт төвлөрч, эхлүүлсэн боловч дуусаагүй төсөл, арга хэмжээ олноор хуримтлагдаж, жилээс жилд төсөвт дарамт учруулж байгаа;
- “PIMIS” системийн бүх үе шатыг шийдвэр гаргагчид буюу Улсын Их Хурлын гишүүдэд нээлттэй болгох;
- Салбарын яамд хооронд чиг үүргийн давхардал үүсч, хөрөнгө оруулалтын бодлого нэгдсэн удирдлага, зохицуулалтгүйгээр хэрэгжиж байгаа.

## **2. Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах үе шатанд**

- Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж буй хүний нөөцийг чадавхжуулах;
- Тендер шалгаруулалтыг хугацаанд нь зохион байгуулж чадахгүй байдал түгээмэл байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удаашруулж байна;
- Орон нутагт хэрэгжиж буй барилга байгууламжийн төслүүдэд гүйцэтгэгчийн чадавх, материал нийлүүлэлт, ложистикийн асуудал хүндрэл үүсгэж, хугацаа алдагдах, чанарын доголдол үүсэх нөхцөл бүрдэж байна;
- Жил дамнасан төслүүдэд инфляц, үнийн өсөлтийн нөлөөг бодитоор тооцох механизм сул байгаагаас өртөг нэмэгдэж, төсвийн ачаалал өсөх хандлагатай байна.

## **3. Техникийн тодорхойлолт, зураг төсөл, стандартын хувьд**

- Ижил төрлийн барилга байгууламжид тавигдах тендерийн шаардлага, шалгуур үзүүлэлт харилцан адилгүй, уялдаа муутай байгаа;
- Ажлын даалгавар, зураг төсөл боловсруулах үе шатанд захиалагч байгууллагын ажлын даалгавар дутуу, буруугаас болж гүйцэтгэлийн явцад зураг, төлөвлөлтөд өөрчлөлт орж, үүнээс шалтгаалан зардал нэмэгдэж, ажил гүйцэтгэх хугацаа хойшлох;
- Тендер шалгаруулахдаа бага үнийн саналаар сонгон шалгаруулалт хийдэг нь чанар муу барилгын материал сонгох, түүнээс улбаалан эрүүл аюулгүй байдлын чанар алдагдах эрсдэл бүрдэж байна. Ялангуяа барилгын дотор засалд ашиглах будгийн чанарт онцгой анхаарахгүй бол дотоод орчны агаарт сөргөөр нөлөөлж байна.
- Төслийн анхны төлөвлөлт, зураг төслийн чанар хангалтгүйгээс хэрэгжилтийн шатанд олон удаагийн засвар, өөрчлөлт хийх шаардлага үүсдэг.

## **4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо**

- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхой бус, олон улсын жишигт нийцээгүй;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо сул, үр дүнд суурилсан үнэлгээ хангалтгүй;
- Төсөл хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

## **5. Бодлого, институцийн зохицуулалтын хүрээнд**

- Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого салбар бүрийн онцлогт нийцсэн байдлаар төлөвшөөгүй;
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд үүсэж буй эрсдэл, үнийн хэлбэлзэл, зах зээлийн нөхцөлийг бодлогоор зохистой зохицуулах шаардлага байна;
- Чанартай, үр ашигтай цөөн төсөл хэрэгжүүлэх бодлогын чиглэл тодорхой бус байна.

## **Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж**

Дээрх нөхцөл байдалд үндэслэн хэлэлцүүлэгт оролцогчид дараах санал, зөвлөмжийг дэвшүүлэв. Үүнд:

### **1. Төлөвлөлт, эрэмбэлэлтийг сайжруулах чиглэлээр**

- Төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгахдаа техник, эдийн засгийн үндэслэл, бэлтгэл ажлыг бүрэн хангуулсан байх шаардлагыг хууль, журмаар хатуу мөрдүүлэх;
- Шинэ төсөл эхлүүлэхээс өмнө эхлүүлсэн боловч дуусаагүй төсөл, арга хэмжээг бүрэн дуусгах эрэмбийн бодлогыг чанд хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын бодлогын төвлөрсөн удирдлага, зохицуулалтыг сайжруулж, чиг үүргийн давхардлыг арилгах.

### **2. Хэрэгжилтийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр**

- Тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог чангатгах;
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа чадавх, туршлага, нөөц боломжийг бодитой үнэлэх;
- Жил дамнасан төслүүдийн үнийн зөрүү, инфляцын нөлөөллийг тооцох санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох.

### **3. Техникийн бодлого, стандартын хүрээнд**

- Тендерийн баримт бичиг, шаардлагыг нэг мөр болгох, ижил төрлийн барилга байгууламжид нэгдсэн стандарт мөрдүүлэх;
- Зураг төсөл, ажлын даалгавар боловсруулах шатанд мэргэжлийн байгууллагын оролцоог зайлшгүй хангах;
- Төслийн анхны зураг төслийн чанарыг сайжруулж, хэрэгжилтийн явц дахь өөрчлөлтийг багасгах.

### **4. Хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулах чиглэлээр**

- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хугацаа, өртөг, үр ашгийн үзүүлэлтэд суурилсан олон улсын жишигт нийцсэн шалгуураар үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний хараат бус байдлыг хангах, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгох.

### **5. Бодлого, институцийн шинэчлэлийн чиглэлээр**

- Төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг салбарын онцлогт нийцүүлэн шинэчлэх;
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, эрсдэлийг бууруулах зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Чанартай, үр ашигтай, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлэх бодлогыг тодорхой болгох.

## **Дүгнэлт**

Нээлттэй хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөл сонгон шалгаруулалт, хэрэгжилт, хяналтын тогтолцоог бүхэлд нь хамарсан цогц шинэчлэл хийх, ил тод, хариуцлагатай, үр ашигт суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлэх шаардлага байгааг оролцогчид санал нэгтгэйгээр онцлон тэмдэглэв.

Дээрх санал, зөвлөмжийг “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, цаашдын бодлого, эрх зүйн зохицуулалтад тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

### **Хоёр. D-Parliament.mn-д цахим системээр иргэдээс авсан санал**

Монгол Улсын Их Хуралд өргөн барьж буй тогтоолын төслийн хүрээнд D-Parliament.mn цахим системд байршуулж, иргэд дараах саналыг гаргав.

#### **Төсөл, арга хэмжээний мэдээллийн ил тод байдал, системчлэл**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, үнэлэх, төлөвлөх, батлах үйл явцын тоон мэдээллийг системчлэх, стандартчилах шаардлагатай гэж үзсэн. Иргэдээс ирүүлсэн саналд дурдсанаар, дээрх чиглэлээр цахим системийн хөгжүүлэлт хийгдэж байгаа хэдий ч хууль тогтоогч, ялангуяа Улсын Их Хурлын гишүүдэд тухайн процессын явцыг шууд хянах, ажиглах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй гэж санал нэгтэй илэрхийлсэн болно.

#### **Төсвийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх асуудал**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй холбоотой:

- төсвийн төлөвлөлт,
- Улсын Их Хурлаар баталсан болон өөрчлөн баталсан төсөв,
- төсвийн гүйцэтгэлийн тоон мэдээлэл зэргийг нэгтгэсэн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Ингэснээр шийдвэр гаргагчид бодлого боловсруулах, хяналт тавих үйл ажиллагаанд ашиглахад хялбар, хүртээмжтэй орчин бүрдэнэ гэж иргэд санал нэгтэй дэмжсэн болно.

#### **Эрх зүйн орчны уялдаа, хэрэгжилтийг сайжруулах санал**

Тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, шаардлага хангах байдлыг хянах хүрээнд мөрдөгдөж буй эрх зүйн актуудад:

- дүн шинжилгээ хийх,
- хууль тогтоомжийн уялдаа, нийцлийг хангах,

- давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцын талаар тухай бүр мэдээлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгах нь зүйтэй гэж санал ирүүлсэн.

Мөн дээрх арга хэмжээний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг хаврын чуулганы төгсгөлд Байнгын хороонд танилцуулдаг байх, уг чиг үүргийг Засгийн газарт даалгаж, шаардлагатай тохиолдолд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн болно.

### **Тогтоолын хэрэгжилт, хэлэлцэх дарааллын талаар**

Энэхүү тогтоолын төслийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын эхний эрэмбэд оруулах, хэрэгжилтийг шуурхай хангах зорилгоор:

- Засгийн газар холбогдох саналаа боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах,
- 2027 оны улсын төсвийн төсөл өргөн барихаас өмнө холбогдох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж иргэд санал болгосон.

---o0o---